



Шинжээчийн үнэлгээний тайлан

Байгууллагын нэр: ЭТҮГЭН ИХ СУРГУУЛЬ
ИНЖЕНЕРЧЛЭЛ-ЭДИЙН ЗАСАГ, МЕНЕЖМЕНТИЙН
СУРГУУЛЬ

Хөтөлбөрийн нэр: ҮЙЛДВЭРЛЭЛИЙН АВТОМАТЖУУЛАЛТ
(ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН
ИНЖЕНЕР)

Индекс: D071402

Шинжээчийн баг:

Ахлагч: Б.Бат-Эрдэнэ

Гишүүд: Ц.Мягмарнаран
Р.Эрдэнэчимэг

2021.12.15

Агуулга

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	ЭТҮГЭН ИХ СУРГУУЛЬ, ИНЖЕНЕРЧЛЭЛ-ЭДИЙН ЗАСАГ, МЕНЕЖМЕНТИЙН СУРГУУЛЬ	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	ҮЙЛДВЭРЛЭЛИЙН АВТОМАТЖУУЛАЛТ, (ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ИНЖЕНЕР)	
Индекс	D071402	
Шинжээчид	Ахлагч: Б.Бат-Эрдэнэ Гишүүд: Ц.Мягмарнаран Р.Эрдэнэчимэг	
Зохицуулагч	Б.Оюунчимэг Магадлан итгэмжлэл хариуцсан шинжээч	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	2021/10/27	Ажлын албаны захирлын тушаалаар томилогдсон.
	2021/10/29	Ажлын албаны захиралтай гэрээ байгуулсан.
	2021/11/11	Урьдчилсан үнэлгээний тайланг ажлын албаны мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн.
	2021/11/18	Сургууль дээр илрэл нотолгоотой танилцаж, уулзалт хийсэн.
	2021/11/29	Шинжээчийн багийн тайланг ажлын албанд хүлээлгэн өгсөн.
	2021/12/03	Шинжээчийн багийн тайланг сургуульд илгээн санал авсан.
	2021/12/13	Шинжээчийн баг тайланг эцэслэн боловсруулж, ажлын албанд хүлээлгэн өгсөн.
		Мэргэжлийн зөвлөлийн хурлаар үнэлгээ, дүгнэлтээ хэлэлцүүлэх

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Зорилго: Хүн чанартай мэргэжлийн ёс зүйтэй, харилцааны өндөр ур чадвартай, эрүүл мэндийн боловсрол олгох, дэмжих, хамгаалах, тусламж үйлчилгээг чанартай үзүүлэх, эмнэлгийн тоног төхөөрөмжүүдийн хэвийн ажиллагааг хангах, шалгалт тохируулгыг хийх, төхөөрөмжийн ажиллагааны чанарын үзүүлэлтийн баталгаажилтыг нарийвчлан гүйцэтгэх, угсралт засвар үйлчилгээний үйл ажиллагааг удирдан чиглүүлэх онолын өндөр мэдлэгтэй, практикийн дадлага туршлагатай мэргэжилтэн бэлтгэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

Хөтөлбөрийн хүрэх үр дүн PLOs (Program Learning Outcomes): ЭИС-н алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйл, стратегийн бодлого чиглэлд суурилан хөтөлбөрийн зорилго, зорилтын дагуу хөтөлбөрийн хүрэх үр дүнг (1) мэргэжлийн мэдлэг сэтгэлгээ, (2) хувь хүний болон мэргэжлийн ур чадвар, хандлага, (3) хүмүүстэй харилцах, багаар ажиллах ур чадвар, (4) салбар болон нийгэмд чиглэсэн үр дүнтэй үйл ажиллагаа явуулах чадвар гэсэн 4 бүлэг бүхий 19 ур чадвар, 72 шалгуур үзүүлэлтээр тодорхойлон хичээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлдэг байна.

Хөтөлбөрийн зорилтууд PEO (Program Educational Objectives): Сургалтын хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд бэлтгэгдсэн мэргэжилтэн нь аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, нарийн мэргэжлийн клиникийн эмнэлгүүдэд болон эмнэлгийн тоног төхөөрөмж ба эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх компаниудад ашиглалт, угсралт, засвар үйлчилгээний үйл ажиллагааг удирдан гүйцэтгэх, хяналт шалгалт, тохируулгыг хийх, төхөөрөмжийн ажиллагааны чанарын үзүүлэлтийн баталгаажилтыг нарийвчлан гүйцэтгэх онолын мэдлэгийг бүрэн хангасан мэргэжилтэн бэлтгэхэд хөтөлбөрийн ерөнхий зорилт оршино.

Хөтөлбөрөөр төгсөгч оюутны загвар: Хөтөлбөрөөр төгссөн оюутнууд нь дараах зорилтуудыг хангасан байхаар тусгаж өгсөн байна (Өөрийн үнэлгээний тайлан: Хавсралт 1.1). Үүнд:

Зорилт 1. Тухайн хөтөлбөрөөр бэлтгэгдсэн мэргэжилтэн нь байгаль, нийгмийн ухааны суурь мэдлэг, цахилгаан, электроникийн инженерийн үндсэн суурь мэдлэг, чадварыг эзэмшсэн байна.

Зорилт 2. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерийн хөтөлбөр нь онолын мэдлэгээ практикт хэрэгжүүлэх, бие даан хөгжүүлэх, асуудлыг шийдвэрлэхдээ системтэйгээр тунгаан бодох, хувийн болон мэргэжлийн авьяас чадвараа хөгжүүлэх чадварыг эзэмшүүлнэ.

Зорилт 3. Технологийн асуудлыг бие даан турших, судалгаа шинжилгээ хийх, судалгааны үр дүнд хүрэх зорилго, зорилтыг тооцоолох, шийдвэрлэх мэргэжлийн сэтгэлгээ, ур чадварыг бүрэн эзэмших.

Зорилт 4. Эрүүл мэндийн салбарын эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерийн ажлын байранд хамтран ажиллах, харилцааны ёс зүйтэй, хариуцлагатай, хувийн зохион байгуулалт сайтай хувь хүн болгон төлөвших.

Зорилт 5. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерийн хариуцах ажлын хүрээнд асуудлыг төлөвлөх, хэрэгжүүлэх чадвартай, компьютер, гадаад хэлний мэдлэгтэй, цаашид дараагийн шатны сургалтуудад гадаад болон дотоодод суралцах чадвартай мэргэжилтэн бэлтгэх.

Сургалтын төлөвлөгөөний бүтэц

- Ерөнхий суурь хичээл **41** багц цаг (30.8%) байна. Үүнээс **37** багц цагийг заавал судлах байдлаар, үлдсэн **4** багц цагийг санал болгож буй хичээлээс сонгон судална.
- Мэргэжлийн суурь хичээл нийт **34** багц цаг (25.5%) байна. Үүнээс **30** багц цагийг заавал судлах байдлаар, **4** багц цагийг санал болгож буй хичээлээс сонгон судална.
- Мэргэжлийн хичээл **50** багц цаг **8** багц цаг дадлага, төгсөлтийн ажил (43.7%) байна. Үүнээс **37** багц цагийг заавал судлах байдлаар, **3** багц цагийг санал болгож буй хичээлээс сонгон судална.

Хөтөлбөрийн хичээлийн онол, практикийн харьцуулалт: Үйлдвэрлэлийн автоматжуулалт (эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер) мэргэжлийн хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөг БШУС-ын яамны А/174 тоот тушаал, Этүгэн их сургуулийн сургалтын нэгдсэн журмын 4.8.1-д заасны дагуу бакалаврын сургалтын нэгдсэн хөтөлбөрийн “Нийтлэг шаардлага”-г хангасан байхаар багц цагийг ерөнхий эрдмийн хичээл 30%, мэргэжлийн суурь хичээл 25%, мэргэшүүлэх хичээл 45% тус тус эзэлж байхаар боловсруулсан байна.

Сургалтын төлөвлөгөөнд нэг хичээлийн багц цаг нэг улиралд багтаан судлах боломжтой байна. Агуулгын багтаамж ихтэй хичээлээс 2 болон түүнээс дээш улирал дараалан эсвэл дараалсан бус улиралд судлахаар баталсан тохиолдолд хичээлийг агуулгын залгамж холбоогоор тусдаа нэр, индекс, багц цагтай байна. Тухайн хичээл бүрээр суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг үнэлнэ.

Лекцийн цаг 16 цаг, эсвэл семинар, лаборатори, дадлагын 32 цаг, тэдгээрт суралцагчийн харгалзах бие даан гүйцэтгэх ажил 48 цаг байна. 133 багц цагаар сургалт зохион байгуулагдаж, сургалтын хөтөлбөрт лекц 57.5, семинар лаборатори 57, поток семинар 4, дадлага 5 багц цаг гэсэн тус тус харьцаатай байна.

Хөтөлбөрт мэргэжлийн хичээл заадаг багш нарын эрдмийн зэрэг

Багшийн эрдмийн зэрэг	2017-2018	2018-2019	2019-2020	2020-2021	2021-2022
Магистр	11	9	13	17	20
Доктор	10	10	10	10	10

Хөтөлбөрийн нэг багшид ноогдох оюутны тоо (ӨҮТ-н Хүснэгт 5.3)

Багш, оюутны тоо	2016-2017	2017-2018	2018-2019	2019-2020	2020-2021
Багшийн тоо	21	19	23	27	30
Оюутны тоо	121	145	162	139	127
Нэг багшид ноогдох оюутны тоо	5.7	7.6	7	5.1	4.2

Хөтөлбөрийн онцлог:

Хөтөлбөр нь дотоод болон гадаадын боловсролын чиг хандлага дээр тулгуурлан судалгаа хийгдсэн. Тухайлбал олон улсын түвшинд бэлтгэдэг ижил төстэй мэргэжлийн судалгаа, мэргэжлийн эрэлт хэрэгцээтэй холбоотой Монгол Улсад шаардлагатай тэргүүлэх чиглэлийн мэргэжлийн жагсаалт, эрүүл мэндийн салбарт ажиллаж буй эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер техникийн ажилчдаас авсан судалгаа, ажил олгогчдоос авсан судалгаа зэрэгт үндэслэгдэн боловсруулагдсан байна.

Хөтөлбөрөөр оюуны өмчийн гэрчилгээ авч баталгаажуулсан. Хөтөлбөрийн шалгуур тус бүр дээр SWOT шинжилгээ хийсэн. Хөтөлбөрийн сайжруулалтыг оролцогч талууд, оюутан, багш, төгсөгчид, ажил олгогчдын санал дээр тулгуурлан гүйцэтгэдэг. Оюутны эзэмших ур чадварыг 19 бүлэг ур чадварт хуваан сайжруулалт хийсэн.

Хичээл тус бүр дээр үнэлгээ хийх шалгуур хуудас нэвтрүүлсэн. Судалгаан дээр суурилсан асуудал шийдвэрлэх систем ашигладаг. Хөтөлбөрийн багш, оюутны хөгжилтэй холбоотой оюутнаар нийгэмд үйлчлэх ажил хийлгэх, өглөөний хүн, эртэч шувуухай зэрэг хөтөлбөр хэрэгжүүлдэг. Багшийн хөгжилтэй холбоотой ЭИС-н грант олгох, багш нарын ажлын гүйцэтгэлийг үнэлж урамшууллын мөнгөн хадгаламж үүсгэдэг байна.

Сургалтын орчин, оюутны орчинг сайжруулж байгаа. Тухайлбал багш нарын ажлын орчин, өрөө, оюутантай уулзах хэсэг, амрах булан зэргийг гаргаж өгсөн. Шилдэг орчинтой сургуулиар шалгарч байсан. Энэ нь оюутны орчинг сайжруулж байгааг харуулж байна. Жишээлбэл сургуулийн байрны хана дээр үзүүлэн хийж өгсөн, ус цэвэршүүлэгч байрлуулсан, үнэгүй чацаргана, талх өгөх, оюутны хамтын ажиллагаа, багаар ажиллах өрөө гаргаж өгсөн байна.

Оролцогч талуудын хамтын ажиллагааг сайжруулах, цахим үйлчилгээг нэвтрүүлэх чиглэлээр зарим ажлууд хийгдсэн. Удирдлага мэдээллийн системийг багш, оюутан, сургалтын бодлого зохицуулалтын хэсэг, санхүү, хяналт & monitoring талбаруудаар хөгжүүлж ашиглаж байна. Мэдээллийн технологийн алба байгуулж хөгжүүлэлтийг хангаж байгаа ба мэдээллийн аюулгүй байдлыг хангадаг байна.

Ш. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

1. Нийгэм, эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг харуулсан SWOT, TOWS шинжилгээ хийсэн.
 - Тухайн мэргэжил, чиглэлээр олон улсад хэрхэн мэргэжилтэн бэлтгэдэг талаар судалсан. “Алсын хараа: 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер мэргэжлийн хэрэгцээ шаардлага байгааг эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлэх төлөвлөгөө хэсгээс тодорхойлж гаргасан.
 - Мэргэжлийн эрэлт хэрэгцээтэй холбоотой Монгол Улсад шаардлагатай тэргүүлэх чиглэлийн мэргэжлийн жагсаалт, олон улсын зарим судалгаанууд, эрүүл мэндийн салбарт ажиллаж буй эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, техникийн ажилчдаас авсан судалгаа, ажил олгогчдоос авсан судалгаа зэргээс эх сурвалж авч судалгаа хийсэн байна.
2. Дотоод, гадаадын ижил төстэй бэлтгэдэг мэргэжлүүдтэй харьцуулсан судалгаа хийсэн. (Дотоодод: ШУТИС, ЭХС, гадаад орны хувьд: Азын орнуудын био-анагаахын инженерийн сургалтын хөтөлбөрүүдтэй харьцуулсан судалгаанууд хийсэн) 2014 оны үндэсний мэргэжлийн хүрээ хэлэлцүүлэг хийсэн байна. Уг хэлэлцүүлгээс “Үйлдвэрлэлийн автоматжуулалт” мэргэжлийн чиглэлд “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер” мэргэжлийг электроник суурьтай тул уг салбар чиглэлд оруулах нь зүйтэй гэсэн шийдвэр гаргасан байна.

Зөвлөмж:

- Нийгэм, эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг харуулсан шинжилгээг илүү нарийвчлан хийх (STEER шинжилгээ хийх), судалгааны эх сурвалжуудыг сүүлийн үеийн өгөгдөл ашиглаж гүйцэтгэх.
- Олон улсын түвшинд адил төстэй мэргэжилтэн бэлтгэдэг сургуулиудын судалгааг дэлхийн нэр хүндтэй их сургуулиудтай харьцуулан өргөтгөж гүйцэтгэх. Тухайлбал Америк, Европын их сургуулиудтай харьцуулж болох юм.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

1. Хөтөлбөрөөр төгсөгчийн загвар, зорилго зорилгоо Монгол Улсын боловсролын талаар төрөөс баримтлах бодлогууд, Боловсролын тухай болон дээд боловсролын тухай хууль, ЭИС-н алсын хараа, эрхэм зорилго, хөгжлийн стратеги төлөвлөгөө, салбарын хөгжлийн чиг хандлага, тухайн мэргэжлийн хүний нөөцөд тавигдах шаардлага зэрэгт үндэслэн боловсруулсан байна. Төгсөгчийн загварыг ӨҮТ-н Хавсралт 1.1-д заасан байна.
2. Хөтөлбөрийг 2014 болон 2018 онуудад сайжруулан өөрчилсөн ба PLO-г 4 бүлэг 19 ур чадвар, 82 шалгуур үзүүлэлтээр тодорхойлон 2020 оны 3 сарын 19-нд ур чадвар дээр өөрчлөлт оруулж сайжруулсан.
 - a. Төгсөгчдөөс 2014–2020 онуудад жил бүр PLO-г 4 бүлэг, 19 ур чадварыг хэрхэн эзэмшсэн талаар сэтгэл ханамжийн судалгаа авсан. “Маш их сэтгэл ханамжтай” гэсэн үнэлгээ 2019 онд 83.3%, 2020 онд 74.1% байсан байна.
 - b. Ажил олгогчийн судалгааг 2015, 2020 онуудад дээд боловсролын шинэчлэл төслийн хүрээнд авсан. Эндээс 19 ур чадварыг тодорхойлж гаргасан. 2017 оноос хэрэгжиж эхэлсэн байна. Нийт 33 байгууллагаас судалгаа авсан. Салбар, салбарын байгууллагуудын төлөөлөл, инженер 6 хэсэг, 27 асуулттай асуулгаар судалгааг хийж гүйцэтгэсэн.
3. Хөтөлбөрийн зорилго, зорилт, өөрчлөлтийн талаар олон нийтэд мэдээлэхдээ сургуулийн удирдлага мэдээллийн системийн оюутны хэсэгт байршуулдаг. Мөн хичээлийн жилийн эхэнд шинэ элсэгчдийн сургалт хийж хөтөлбөрийн танилцуулга хийдэг. Оюутны сэтгэл ханамжийн судалгаагаар эмхэтгэл гаргадаг ба сүүлийн 3 жилээр их сургуулийн түвшинд, салбар сургууль, мэргэжлийн тэнхим, мэргэжил хөтөлбөрийн хүрээнд харьцуулалт хийгддэг. Удирдлага мэдээллийн системээс оюутан судалгааг бөглөдөг. Хичээл 100 хувь дууссаны дараа санал асуулга явагддаг байна.

Онцлог зүйл/Туршлага:

- Хичээлийн жилийн эхэнд хөтөлбөрийн зорилго, зорилт, өөрчлөлтийн талаар шинэ элсэгчдийн сургалт зохион байгуулж танилцуулах, мэдээлэх ажил зохион байгуулдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

1. Оролцогч талуудын санал зөвлөмжийг тусгах зорилгоор хөдөлмөрийн яамны судалгаа, “Status of biomedical engineering education in the asia pacific” өгүүлэл дээрх

мэдээллүүд, сургуулийн стратеги төлөвлөгөөний дагуу Азийн сургуулиудын жишээн дээр судалгаануудыг хийж гүйцэтгэсэн.

- a. Сургалтын хөтөлбөрийг БСШУ-ны сайдын 2014 оны А/174 тоот тушаалын бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг 12 шаардлагын дагуу боловсруулж ЭИС-н ректорын 2017.06.21-ны 43 тоот тушаалаар батлуулсан байна. Үүнтэй уялдан 2021 онд оюуны өмчийн гэрчилгээгээр “Бакалаврын сургалтын хөтөлбөрийн агуулга, арга зүй, аргачлалын эмхэтгэл”-г баталгаажуулсан байна.
- b. Мөн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд туслах, удирдлага зохион байгуулалтаар хангах зорилго бүхий 12 бүлэг, 170 хавсралт бүхий баримт бичгийг 2019 оны 11 сарын 08-ны 112 тоот тушаалаар батлан хэрэгжүүлж байгаа. Батлагдсан сургалтын төлөвлөгөөг ӨҮТ-н Хавсралт 2.3-т оруулсан байна. Сургалтын нэгдсэн журмын эмхэтгэл 2019 онд хэвлэгдэн гарсан ба эмхэтгэл дээр бүх дүрэм журам хэвлэгдсэн.
2. Тэнхимийн 2016-2021 оны хурлын тэмдэглэлийг эмхэтгэл болгож архивлан хадгалсан байна. Мөн хөтөлбөрийн удирдлагын багийн 2017-2021 оны хурлын тэмдэглэлийг эмхэтгэл болгож архивлан хадгалсан.
3. Сургалтын нэгдсэн төлөвлөгөө, график матрицыг тодорхойлсон бичиг баримтыг боловсруулан батлуулсан. Хөтөлбөрийн сайжруулалтыг 2013 оноос 2020 он хүртэл үечилсэн байдлаар гүйцэтгэсэн (ӨҮТ-н 23-р хуудас).
4. Батлагдсан хичээлийн хөтөлбөрийг ӨҮТ-н Хавсралт 2.3-т тусгасан. Бодлогын бичиг баримтын хувьд сургуулийн стратеги төлөвлөгөө 2030 эмхэтгэл хоёр төрлөөр хэвлэгдсэн байна.

Онцлог зүйл/Туршлага:

- Оролцогч талуудын судалгаа хийж, судалгаан дээр үндэслэн хөтөлбөрийн төлөвлөлтөд тусгадаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

1. ЭИС-ийн ректорын 2017 оны 06-р сарын 21 өдрийн 43-р тоот тушаал, 2018 оны 01-р сарын 05 өдрийн 05-р тушаалаар ЭТТИ мэргэжлийн хөтөлбөрийн индексийг 071402 дугаараар, хичээллэх хугацааг 4 жил, нийт багц цагийг 133 байхаар баталсан. Суралцахуйн үр дүн, хичээлийн аргазүйг матрицаар үзүүлсэн байна (ӨҮТ-н 27-р хуудас, Хавсралт 1.2).
2. Удирдлагын мэдээллийн системд оюутны хөтөч, хичээлийн хөтөлбөр, лекцийн сэдэв, агуулгыг урьдчилан оруулдаг. Хичээлийн төгсгөлд тухайн хичээл болон заасан багшид хичээл сонгосон оюутнууд өөрсдийн үнэлгээг хийдэг.
3. ЭТТИ мэргэжлийн хөтөлбөрт анализ хийж, ЭИС-ийн нийт мэргэжлийн хөтөлбөрт эзэмшвэл зохих 19 ур чадварыг тус хөтөлбөрт /ЭТТИ/ 72 шалгуураар тусгаж, сургалтын төлөвлөгөөнд сонгон хичээлүүдийг нэмсэн, агуулга ижил хөтөлбөрүүдийг нэгтгэх зэргээр нийт багц цагийг 133 болгож баталсан.
4. ШГТЭ-тэй 2019 оны 09-р сарын 01-с 3 жилийн хугацаатай хамтын ажиллагааны гэрээ байгуулсан. ХУД-ийн ЭМТөв, ХУД-ийн Нэгдсэн Эмнэлэг, “Турван гал” эмнэлэгтэй бааз эмнэлгийн гэрээтэй. Дадлагыг суралцагсдын санал болон багшийн хуваарилсан эмнэлэг, ханган нийлүүлэх байгууллага дээр дадлагын удирдамжид заасан мэдлэг, ур чадварыг эзэмшүүлдэг.
5. Сургалтын төлөвлөгөөний хичээл хоорондын залгамж холбоо, өмнөх холбоосыг ӨҮТ-н хуудас 17-д зааж өгсөн байна.
6. Суралцагчийн цагийн ачаалал тооцсон судалгааг ӨҮТ-н 37-р хуудаст зааж өгсөн.

Онцлог зүйл/Туршлага:

- Хичээлийн хөтөлбөр бүрд рубрик үнэлгээний аргаар эзэмшвэл зохих мэдлэг, ур чадварын үнэлгээг тогтоосон. Хичээлийн хөтөлбөрийг 2014, 2017, 2018, 2020 онд сайжруулалт хийсэн, рубрик үнэлгээний аргыг хөтөлбөр бүрд тусгасан.
- Оюутан бүр дадлага ажлын дэвтрийг үйлдвэрлэлийн дадлагын үед ашигладаг.
- ЭИС-ийн “стратеги 2030” хөгжлийн бодлогыг боловсруулсан. Үүнд ЭТТИ мэргэжлийн хөтөлбөрт зориулсан лаборатори байгуулах ажил болон төсвийг суулгаж өгсөн байна.

Анхаарах асуудал:

- Хичээлийн хөтөлбөрийн нийт багц цаг хоорондоо зөрөөтэй байсан. Энийг засаж залруулах (ӨҮТ-н хуудас 37, Хүснэгт 2.11, Хавсралт 2.3 зэргийг шалгах).

Зөвлөмж:

- Дадлагын талаар хамтран ажиллах гэрээнд мэргэжил тус бүрийг хавсралтаар тусгах

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

1. ЭИС-ийн ректорын 2017 оны 12-р сарын 27-ний өдрийн 95-р тоот тушаалаар оюутны үнэлгээний арга, аргачлалыг сайжруулах, анализ хийх комиссын бүрэлдэхүүнийг баталсан. Тухайн хичээлийн агуулга болон бүлэг сэдвийн хувьд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадварыг үнэлэх шалгуур хуудсыг ашигладаг.
2. Суралцагч, төгсөгч нараас сургалтын аргазүй, эзэмшвэл зохих 19 ур чадвар эзэмшилтийн байдал, сургалтын орчин, багшийн хамтын ажиллагааны чиглэлээр 26 асуумж бүхий судалгааг 2019, 2020 онд тус тус хийсэн (ӨҮТ-н 25-р хуудас).

Онцлог зүйл/Туршлага:

- ЭИС-ийн 2018 онд баталсан сургалтын нэгдсэн журмаар агуулгын хүрээнд ижил төстэй өөр хичээлүүдийн хувьд багш нар хамтран “сайн хичээл”-ийн удирдамж, төлөвлөгөө боловсруулж, нээлттэй хичээл хэлбэрээр гүйцэтгэдэг.

Зөвлөмж:

- ЭТТИ мэргэжлийн сургалтын төлөвлөгөөнд оюутнуудын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх, ажлын байран дээр ажиллах үед шаардлагатай чиглэлээр мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээлийн нэр төрөл, багц цагийг нэмэгдүүлэн тусгах. Оюутны суралцах хэлбэр дээр практик туршилтууд түлхүү оруулах, эмнэлэг, ханган нийлүүлэх компаниуд дээр очиж дадлагын хичээл хийх боломжийг хангах.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

1. ЭИС-ийн ректорын 2017 оны 12-р сарын 27-ний өдрийн 95-р тоот тушаалаар оюутны үнэлгээний арга, аргачлалыг сайжруулах, анализ хийх комиссын бүрэлдэхүүнийг баталсан. 2018 онд ЭИС-ийн үнэлгээний зөвлөмж гарын авлага хэвлэгдэж, сургалтын үйл ажиллагаанд нэвтрүүлсэн. Уг гарын авлагад Блумын таксаномийн аргаар санах, ойлгох, хэрэгжүүлэх, задлан шинжлэх, үнэлэх, бүтээх гэсэн 6 түвшинд, Рубрикийн 5 түвшинд суралцагчийг үнэлэх аргачлалыг хичээл тус бүрийн хөтөлбөрт оруулж өгсөн.
2. ЭИС-д элсэн суралцагчийг гарааны үнэлгээ, ахицын үнэлгээ, төгсөлтийн шалгалтын үнэлгээ гэсэн 3 төрлийн үнэлгээгээр суралцах хугацаандаа үнэлж, танилцуулдаг. Судалгааны үр дүнг хөтөлбөрт тусгадаг.
3. ЭИС-ийн мөрдөх сургалтын нэгдсэн журмаар явцын болон төгсөлтийн шалгалтыг зохион байгуулдаг (Этүгэн их сургуулийн дүрэм, журмын эмхэтгэл, 6, 7-р бүлэг, ӨҮТ-н 50-р хуудас).
4. Жил бүр суралцагчийн сурлагын амжилт, сурлагын чанарт судалгаа хийдэг. 5 жилийн дунджаар сурлагын амжилт 95.6%, чанар 49.6% тус тус гарсан байна (ӨҮТ-н 47-49-р хуудас).

Онцлог зүйл/Туршлага:

- Суралцагч тухайн хичээлийг судалж дууссаны дараа багшийн заах аргазүйд УМС-р дамжин 11 асуумжаар үнэлгээ өгдөг. Оюутны мэдээллийг үнэлгээнд харуулдаггүй.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

1. Сургалтын зориулалттай барилга байгууламж нь байр, талбайн хэмжээ, эрүүл ахуйн нормативыг хангасан. Үүнд: хичээлийн байрны ашигтай талбай 12.698 м², эдлэн газрын хэмжээ 4.562 м², хичээлийн байрны нийт суудлын тоо 4000, ариун цэврийн өрөө 37, угаалтуур 60, суултуур 53, нэг оюутанд ноогдох ашигтай талбай 7.4, лекцийн заал 7, дотуур байр 2 (350 оюутан, 2200 м²) суралцагч болон багш нарын эрүүл чийрэг, ажиллаж сурч боловсроход туслах 1700 м², олон улсын стандарт хангасан спорт заал, фитнес, усан бассейн цогцолбортой, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, нийгмийн харилцаанд оролцоход тулгамдсан асуудлыг даван туулахад багаар ажиллахад, хүнлэг, ёс суртахуун бүхий мэргэжилтэн бэлтгэх, өөрийгөө хөгжүүлэхэд оролцох боломжтой үйлчилгээний газар орчинг бүрдүүлсэн байна (ур чадварын төв, галын аюулгүй ажиллагааны тусгай комисс, хоолны газар).
2. Сургалтын орчны сэтгэл ханамжийн судалгааг 2017 оноос хойш тасралтгүй хийсэн бөгөөд суралцах орчин хангалттай сайн бүрдсэн гэж үнэлгээ өгсөн ч тэдний санал хүсэлт төлөвлөгөөт хуваарийн дагуу 2017-2021 оны хичээлийн жилд уг хөтөлбөртэй холбоотой хөрөнгө оруулалт хийсэн (шууд бус 661,265 шууд 755,666-сургалт судалгаа явуулах болон лабораторийн тоног төхөөрөмж, ном сурах бичиг, гарын авлага). Багаар ажиллах, бие даан суралцах боломжийг хангах, оюутны энтрепренёр сэтгэлгээ хөгжүүлэхэд төсвийн тодорхой хувийг зарцуулсан бөгөөд суралцагсдын орчны сэтгэл ханамжийн судалгаа 2019-2020 онд 56 хувь нь сэтгэл ханамжтай гэсэн байна. Хичээлийн 1, 2, 4-р байрны лекцийн заалнууд сургалтын орчин үеийн тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон, бүх анги танхимд LED TV байрлуулсан.
 - а. Цахим орчны хүртээмж хэрэглээний талаар: патентлагдсан УМС, Lib4U.net үүлэн технологийн програмууд ашигладаг. Бие даан ажиллах болон багаар ажиллах таатай орчин бүрдүүлсэн байна.

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын орчны хувьд стандарт шаардлага хангасан, аюулгүй, тав тухтай, суралцагсдын эрэлт хэрэгцээнд нийцсэн орчинтой байна.

Шаардлага:

- Электроникийн лабораторийн тоног төхөөрөмжид шинэчлэлт хийх. Ажил олгогчдын санал дээр электроникийн суурь мэдлэг, практик дадал муу, сайжруулах шаардлагатай гэсэн санал зөвлөмжүүд гарсан. Хөтөлбөрийн зорилго, зорилтод нийцсэн туршилт хийх боломж бүхий тоног төхөөрөмжүүдийг сонгож шинэчлэлт хийх.
- Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэргэшүүлэх хичээлийн лаборатори байгуулах шаардлагатай. Тухайн мэргэшсэн чиглэл, сонгон суралцах хичээлүүдийн туршилт, дадлага явагдах боломжийг хангах.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

1. Сургалтын хэрэглэгдэхүүн болох мэдээллийн систем, программ хангамж нь сургалтын мэдээллийн санг бий болгох хүрээнд ашиглаж байгаа бөгөөд нэгдсэн тайлан судалгаагаар цаашдын сургуулийн хөгжлийг тодорхойлж, бодлого чиглэл, зөв шийдлийг олоход гол үндсэн хэрэгсэл болгож байгаа нь тодорхой байна. Уг сургалтын хөтөлбөрийн сургалтын хэрэглэгдэхүүн, анги танхим, лабораторийн хүрэлцээг судалсан оюутны сэтгэл ханамж судалгааны үр дүнд 76,6 хувь нь дундаас дээгүүр, 23,3 хувь нь сэтгэл ханамжгүй гэж үнэлсэн байна.
 - a. Багш, санхүү, хөтөлбөр, суралцагсад - ELMS, номын санд - Lib4U.net, сервер хамгаалалт, кабель, дотоод сүлжээний программ хангамжтай байна. Шинээр бүрэн тоноглогдсон дуу бичлэгийн студийг 2019 онд ашиглалтад оруулж, шаардлага хангасан е-контентуудыг сургалтад ашиглаж байна. 2020-2021 хичээлийн жилд Тайван улсын Тайпей их сургуультай хамтарч “Эмнэл зүйн хиймэл оюун ухааны үндэс” хичээлийн хөтөлбөр боловсруулж, хэрэгжихтэй холбоотой сүүлийн үеийн үзүүлэлт бүхий 40 суурин компьютер, хичээлийн агуулгат тохирсон видео контентуудыг үзэх зорилгоор 2 мини кино заалыг 5 дахь жилдээ ашиглаж байна.
 - b. Тухайн хичээлийн лекц, семинарын материал, бие дааж зайлшгүй унших ном, судалгааны хэвлэл зэргийг 10 хоногийн өмнө оюутанд УМС-р хүргүүлж, УМС-д байршсан 6 түвшингийн даалгаврын сантай, хичээлийн хөтөлбөрийг улирлын эхний 7 хоногт байршуулдаг бөгөөд 65 хичээлийн давхардсан тоогоор 1121 хэрэглэгдэхүүн тусгагдсан, үүнээс багш хариуцах хэрэглэгдэхүүн 455, суралцагч хариуцах хэрэглэгдэхүүн 250, сургуульд байгаа хэрэглэгдэхүүн 416 байна (ӨҮТ-н 58-62-р хуудас).
2. Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмжийг сургалтын нэгдсэн журмын зүйл заалтын дагуу тодорхой механизмаар хэрэгждэг байна. Сургалтын ажлыг зохион байгуулах, заавар, удирдамжийн хүртээмж нь тус сургуулийн веб сайт, УМС байршдаг нь ил тод байна (ӨҮТ-н 61-64-р хуудас).
3. Е-контент түвшинд боловсруулсан сургалтын материал тодорхой тусгагдсан бөгөөд сүүлийн 2 жилд видео, аудио хичээл 2216, тест шалгуур хуудас 3674 цахим хичээлийг 6161 удаа холбогдож ажилласан, 2020-2021 оны хичээлийн жилд цахим сургалтын сэтгэл ханамж 87,8 хувьтай нь сургалтын чанар, хүртээмжийг тасралтгүй сайжруулсны үр дүн гэж үзэж байна (ӨҮТ-н 64-65-р хуудас, жишээ контент: <https://www.youtube.com/watch?v=UmFteM0gElc>).

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

1. Этүгэн сургууль 2 номын сантай (etugen.lib4u.net электрон каталог), 2-р байрны номын сан: 250 гаруй оюутны суудалтай, 3 уншлагын танхимтай, чөлөөт болон багаар ажиллах, магистр, докторын уншлагын танхимтай. 5-р байрны номын сан: 105 оюутны суудалтай, багаар ажиллах хоёр танхимтай. 7113 төрлийн 24 мянган ном сурах бичигтэй, эх хэлээр 4579 төрлийн 18335, англи хэлээр 1225 төрлийн 2529 байгаагаас үйлдвэрийн автоматжуулалт сургалтын хөтөлбөрт ашиглах 89 төрлийн 582 номноос 79 төрлийн 771 ном төрөлх хэлээр хэвлэгдсэн байна. 2021 онд нэг суралцагчид 6.1 сурах бичиг ногдож, 10 төрлийн цахим хэлбэрээр номтой, номын сан 136 төрлийн ном оруулснаас тал хувийг идэвхтэй ашиглаж байна. Сүүлийн 5 жилд уг хөтөлбөрийн номын тоо 20 хувь өссөн бөгөөд түүнд 5.7 сая төгрөг зарцуулсан байна (ӨҮТ-н 65-66-р хуудас).
2. “Мэргэжлийн номын хүрэлцээ хангамж”-ийг судалсан дүнгээс харахад 77.5 хувь нь сэтгэл ханамжтай гэсэн үнэлгээ өгсөн байна. Мөн ЭТГИ-н сургалтын хөтөлбөрийн ном сурах бичгийн хэрэглээний мэдээллийн судалгааг гаргасан байна (ӨҮТ-н 66-67-р хуудас).
3. Номын сангийн фондын нэгдсэн бүртгэлтэй, стандартын дагуу бүртгэл, баяжилтыг тогтмол хөтөлдөг, ном сурах бичгийн хүртээмжийн судалгааг жил бүр гарган өгдөг, жилээс жилд уг хөтөлбөрийн ном, сурах бичгийн тоо нэмэгдсэн байна. Цахим каталогийн систем 2021 оноос нэвтрүүлж, цахим нээлттэй эх сурвалжийн хэрэглээг хөгжүүлэх зорилгоор 11 нээлттэй эх сурвалжийг номын санд тогтмол ашиглаж байна (ӨҮТ-н 67-68-р хуудас). Үнэгүй ашиглах боломжтой мэдээллийн холбооснууд энд хэрэглэдэг. Жишээлбэл: www.ebscohost.com. Үүлэн технологи нэвтэрснээр давуу талууд их болсон нь харагдаж байна. Жил болгон төлбөр төлж уг технологийг хэрэглэдэг.

Онцлог зүйл/Туршлага:

- Номын сангийн орчин, нөхцөл сайн. Оюутан тусдаа суух боломжийг олгосон хэсгүүдтэй, зөөврийн суудлуудтай, багаар ажиллах орчинг бүрдүүлж өгсөн.

Зөвлөмж:

- Эрдэм шинжилгээний бүтээл, сэтгүүл, бусад эх сурвалжууд руу багш, оюутан хандаж унших боломжтой төлбөртэй эх сурвалжуудыг ашиглах судалгаа хийж, нэвтрүүлэх.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

1. Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанар, үр дүнг тасралтгүй сайжруулахад чиглэж, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог ханган, нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэн ажилладаг нь 2018-2021 он хүртэл хөтөлбөрийн хэрэгжилтэд тодорхой тусгагдсан байна. Хөтөлбөрийн нэгжийн \тэнхим, хөтөлбөрийн хороо\ шийдвэр гаргалт, хэрэгжилтийн үнэлгээнд багш суралцагсдын оролцоог хангасан тодорхой бүтэц, үйл ажиллагааны 7 хоног бүрийн нэгдсэн хурал, хэлэлцүүлгийн үйл явцыг удирдлагаар ханган, сайжруулах санал чиглэл, шийдвэрийн дагуу сургалтын орц, явц, гарц, үе шатны үнэлгээнд сайжруулалт хийж, эргэх холбоотойгоор ерөнхий хороонд хэлэлцүүлж, дотооддоо баталгаажуулан, тогтолцоо, үйл явцыг хөгжүүлэх ажлууд төлөвлөгдөж, хөтөлбөрийн үр дүнг үнэлэхдээ оролцогч талууд болох ажил олгогч, суралцагч, төгсөгчид, хичээл заасан багш нараас авсан судалгаа, санал асуулга, хичээлийн үр дүнг улирал бүр тодорхойлдог байна.
2. Этүгэн сургуулийн дүрэм, сургалтын нэгдсэн журамд сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, арга зүй, хичээлийн хөтөлбөр боловсруулах, батлах, өөрчлөлт оруулахад БШУЯ-с баталсан журмыг баримталж, СБЗА-ны бодлого, тэнхимийн эрхлэгч, багш нар оюутан, ажил олгогч нарын санал хүсэлтийг тусган ажилласан байна. Тэнхимийн багш нарын хурлын 7 хоногт 1 удаа жилд 30 аад удаа, захиргааны зөвлөлийн хурлыг 7 хоногт 1 удаа жилд 20 аад удаа хийж сургалт, үйл ажиллагаа, хичээлийн хөтөлбөрт өөрийн үнэлгээ хийж, дүгнэлт хийж, сургалт, сайн туршлага, сургалтын технологийг нээх, сайжруулах арга замыг хэлэлцүүлж, шийдвэрээр дахин төсөл хэрэгжүүлдэг, энэхүү үр дүнд тулгуурласан сургалтын хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалтын нэгдсэн журмыг 12 бүлэг, 170 хавсралттайгаар батлан хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн үр дүн болох 19 ур чадварт анализ хийх, дамжаа бүрд эзэмших чадварыг тодорхойлон гаргах, сургалтын хэрэглэгдэхүүн, сурах бичгийн судалгаа гаргах, сайн хичээл, сайн туршлагыг нэвтрүүлэх зэрэг ажлуудыг зохион байгуулж хэрэгжүүлсэн байна.
3. ЭТТИ мэргэжлээр суралцагч оюутнуудын ирүүлсэн санал хүсэлтийг нэгтгэн /2015-2020/ сургуулийн удирдлага, санхүүгийн алба, СБЗА-нд ирүүлсэн цаг тухайд нь 98,9 хувийн гүйцэтгэлтэй шийдвэрлэсэн, Суралцагч нь багшийн хичээл, сургалтын үйл ажиллагааны талаар санал хүсэлтийг илгээдэг. Оюутны хүсэлт, гомдлыг хүлээн авах үйл ажиллагааг улам боловсронгуй болгохоор УМС-ээс энэ улирлаас эхлэн шууд татаж хэрэглэдэг болсон байна. УМС нь өөрийн онцлог, давуу талуудтай /суралцагч таны хөтөч, автоматжуулагдсан шударга систем, суралцагч өөрөөр

өөртөө үйлчлэх, мэдээллийг тасралтгүй хүлээн авах боломж, хамтарсан үйл ажиллагаа явуулах давуу тал, хариуцлагатай, хурдтай цахим орчин, сургалтын иж бүрэн үйл ажиллагааг удирдах / байна. 2016 оноос хойших жил бүрийн тайлан төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээнээс харахад сургалтын үйл ажиллагаа, эрдэм шинжилгээ судалгаатай холбоотой, багшийн мэдлэг боловсролоо дээшлүүлэх, суралцагчдад хандсан, нийгэмд чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл, ахиц дэвшил 80 хувиас дээш байна.

4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч урт (2012-2021), дунд (2007-2012), 2017 оноос хойших богино хугацааны төлөвлөлт, гүйцэтгэлийн тайлан, ахиц өөрчлөлтийн дүн шинжилгээ тайланд тодорхой тусгагдсан, 2030 он хүртэлх стратеги төлөвлөгөөг баталсан байна. Үүнд: сургалт, судалгаа, үйлдвэрлэлийн гурвалсан нээлттэй, дижиталчлагдсан, инноватив хэв шинжийн их сургууль болон хөгжихдөө сургалт, сурах орчинг олон улсын жишигт хүргэх, эрдэм шинжилгээ инновацийг олон улсын жишигт хүргэх, үндэсний болон олон улсад хүлээн зөвшөөрөгдөх нөхцөл боломжийг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулсан байна.
5. Тус тэнхимийн стратеги төлөвлөгөө нь дунд болон урт хугацаанд 40 зорилт дэвшүүлэн 50 үндсэн чиглэлийг тодорхойлж 204 ажлыг төлөвлөж, 35 шалгуур үзүүлэлтээр үнэлэгддэг, төлөвлөгөөний дундаж биелэлт 90.4% байна. Тайлан төлөвлөлтийг УМС-р дамжуулан гүйцэтгэдэг.
6. УМС нь үндсэн 5 бүтцийн нэгж, 114 төрлийн цэсийн дагуу удирдлага, зохион байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлдэг, etugen.edu.mn цахим хуудасны хандалт 2018 онд 3 дахин өссөн. Сургалтын УМС-ийн ашиглалт, хяналт, ил тод байдалд хийсэн тодорхой дүн шинжилгээ хийгдсэн байгаа нь тайлангаас харагдаж байна. Үүнд: оюутны санал, гомдол хүлээн авч хариу өгөх үйл ажиллагаа систем бүрдсэн, улирал бүрийн төгсгөлд сэтгэл ханамжийн судалгаа авдаг, удирдлага мэдээллийн системийн онцлог нь дараах давуу талтай байна (элсэлтээс төгсөгч хүртэл суралцагч таны хөтөч, цаас багатай технологи, мэдээллийн нэгдсэн орчин, хариуцлагатай, хурдтай байх цахим орчин, сургалтын иж бүрэн үйл ажиллагааг удирдах). Мөн цахим хуудас руу хандалт 2018 онд 50.000 байсан бол 2021 оны 4 сарын байдлаар 140.000 өссөн үзүүлэлттэй. Удирдлага, мэдээллийн системд судалгаа, сургалтын үйл ажиллагааны хэрэгцээ, хөгжлийн бодлого, чиглэлийн дагуу төлөвлөгөө гаргаж үе шаттайгаар сайжруулалт хийгдсэн байна.

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг үнэлэхдээ оролцогч талууд болох болох ажил олгогч, суралцагч, төгсөгчид тухайн хөтөлбөрт хичээл зааж байгаа багш нараас авсан судалгаа санал асуулгаар, хичээлийн үр дүнг тухайн хичээлийг сонгон суралцсан оюутны сэтгэл ханамжийн судалгаагаар улирал бүр /2018-2021/ тодорхойлж хэвшсэн.
- Хөтөлбөрийн үр дүн болох 19 ур чадварт анализ хийх, дамжаа бүрд эзэмших чадварыг тодорхойлон гаргах, сургалтын хэрэглэгдэхүүн, сурах бичгийн судалгаа гаргах, сайн хичээл, сайн туршлагыг нэвтрүүлэх зэрэг ажлуудыг зохион байгуулж хэрэгжүүлсэн байна

- УМС нь үндсэн 5 бүтцийн нэгж, 114 төрлийн цэсийн дагуу удирдлага, зохион байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлдэг, etugen.edu.mn цахим хуудасны хандалт 2018 онд 3 дахин өсөж, удирдлага, мэдээллийн системд судалгаа, сургалтын үйл ажиллагааны хэрэгцээ, хөгжлийн бодлого, чиглэлийн дагуу төлөвлөгөө гаргаж үе шаттайгаар сайжруулалт хийгдсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

1. Инженерчлэл-эдийн засаг менежментийн сургууль (ИЭЗМС) 2014 оноос гадаадын 3, дотоодын 5 байгууллага, цаашид хамтран ажиллах хэлэлцээрийн түвшинд 3 байгууллага байна.
2. Багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт 2014 оноос хойш 8 багш Хятад, Солонгос, Тайвань, Япон зэрэг улсуудад багш, оюутан солилцоогоор явж, мэдлэг, ур чадвараа ахиулах, туршлага судлах, өөрийгөө хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулахын зэрэгцээ сүүлийн 5 жилд ЭТТИ-н багш нарын ажлын үр дүнг хэлэлцэж 48 сая орчим, орон гэр, зөөврийн компьютер авах, байр худалдаж авахад нь сургуулийн зүгээс хүүгүй 63 сая төгрөгийн дэмжлэг үзүүлжээ.
3. Нийгэмд үзүүлсэн үйлчилгээг үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгаж, 21 аймгийн ЕБС-ийн 11,12-р ангид улсын хими, биологи, математикийн олимпиад зохион байгуулах, ЭЕШ бэлтгэх зөвлөмж, гарын авлага, сорил бэлтгэх зэрэг үйл ажиллагаа, ЕБ-ын 20 гаруй сургуулийн сурагчдад анхны тусламж, амны хөндийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэлт, үзлэг, зөвлөгөөг жил бүр тогтмол зохион байгуулах, ковид цар тахлын үед ЭМЯ-нд 10 сая, Хятадын монгол улсад суугаа ЭСЯ-д 10 сая төгрөг, Батсүмбэрийн асрамжийн газар, Ид шидийн орон хүүхэд хамгааллын газар, дотуур байрны сурагчдад ариутгал, хоол хүнс, эд материалын дэмжлэг жил бүр үзүүлэх, УБ чуулгын 40 орчим нарийн мэргэжлийн үзлэг үнэ төлбөргүй хийсэн байна.
4. Төгсөгчдийн холбоог 2011 онд 12 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулж, дараах чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг байна. Үүнд: нийт төгсөгчдийн ажлын байрны судалгааг 6 сар дутам хийх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байранд зуучлах, судалгааны ажлыг хөхүүлэн дэмжих, төгсөгчдийн холбоог өргөтгөх зорилгоор соёл, спортын арга хэмжээ зохиох ажлыг хийж гүйцэтгэдэг байна.
5. 2019 онд МЭИН 4-р чуулганы хамтран зохион байгуулсан, тэнхимийн стратеги төлөвлөгөөнд урт, богино хугацааны давтан сургалтад хамруулах талаар тусгасан ч 2018 онд 1 удаа “Хагас дамжуулагч диод, хагас дамжуулагч транзисторууд түүний ажиллагаа” сэдэвт 2 цагийн сургалт зохион байгуулагдсан 13 төгсөгч оролцсон 2019 онд инноваци өдөрлөгийн хүрээнд энтерпренёрийн сургалт зохиогдож ЭТТИ-ээр төгссөн 5 төгсөгч оролцсон байна.

Онцлог зүйл/Туршлага:

- ЭИС-ийн төгсөгчдөд төв усан бассейн, амжилт фитнес, 7 хоног бүрийн 3 дахь өдөр спорт заалаар хөнгөлттэй үнээр үйлчлүүлэх эрх олгох, боломж нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Шаардлага:

- ЭИС-ийн ЭТТИ бакалавр мэргэжлээр төгсгөж эхлээд 7 жил өнгөрч буй тул төгсөгчдийг богино хугацааны давтан сургалт, магистрантурын сургалтад тогтмол хамруулах. Төгсөлтийн дараах сургалтын систем шаардлагатай.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн хувьд сургалт, эрдэм шинжилгээний зардал, багш нарын цалин, урамшуулал, оюутан багшийн үйл ажиллагааны зардлыг сургуулийн нэгдсэн төсөвт төлөвлөх, зарцуулах үйл явцыг хянах баталгаажуулж шийдвэрлэдэг хөтөлбөрийн хөгжлийн хэрэгцээ шаардлагын дагуу 2020-2021 оны хичээлийн жилд эмнэлгийн тоног төхөөрөмжийн лаборатори байгуулахаар шийдвэрлэн төсөв санхүү батлагдсан байна (ӨҮТ-н 92-р хуудас).
2. Нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцоог гаргахдаа нийт суралцагчдын тоог нийт зардлын дүнтэй харьцуулан гаргадаг байна. Сүүлийн 4 жил нэг суралцагчид ноогдох зардал 300.000 төгрөг болсон (ӨҮТ-н 93-р хуудас).
3. Багш нарын цалин, урамшуулал, цагийн ачаалал тооцох, тоног төхөөрөмжийн захиалга, төслийн санхүүжилтийн захиран зарцуулалт, шагнал урамшуулал, багц цагийн сургалтын төлбөрийн 60 хувийг захиран зарцуулах эрхийг хөтөлбөрийн хэрэгжүүлэгч нэгж хэрэгжүүлдэг байна. Сургалтын төлбөрийг жил бүр хичээлийн жилийн эхэнд инфляц, судалгаанд суурилан төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулж, шийдвэрлэдэг, сургуулийн төсвийн орлого суралцагсдын сургалтын төлбөрөөс хамаардаг нь сүүлийн 5 жилийн төлбөрөөс харагдаж байна.
4. Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв, төсвийн зарцуулалтыг 2016-2020 оныхыг харахад төсөв өмнөх үеэсээ 30-40 хувиар нэмэгдэж, 9 багц арга хэмжээнд нийт 5,8 тэрбум төгрөг зарцуулагдсан байна. Энэ төсөв нь тэнхимийн хөгжил, багшийн ур чадварыг хөгжүүлэх, үр дүнтэй хамтын ажиллагаа, цаашдын хөтөлбөрийн хөгжлийн чиг хандлагыг дэмжих зорилгоор зарцуулагдсан байна.
5. Төр, хувийн хэвшлийн дэмжлэг, санхүү түүний зарцуулалтын тайлангаас харахад ЭИС-ийн суралцагсдын сурч боловсрох хүсэл эрмэлзлэлийг дэмжин сүүлийн 5

жилд 424 саяас 1 тэрбум 200 сая хүртэлх төгрөгийн тэтгэлэг хөнгөлттэй зээлийг олгосон байна.

Онцлог зүйл/Туршлага:

- ЭИС-ийн суралцагсдын сурч боловсрох эрмэлзлэлийг дэмжиж тэтгэлэг сайн олгодог. Сургуулийн төсөв, санхүүгийн байдал тогтвортой, бие даасан, ил тод.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

1. ЭТТИ-ийн хөтөлбөрийн төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгааг 2014 оноос эхлэн тогтмол шинэчлэн хийдэг, 2014-2018 онд ажил эрхлэлт 72 хувьтай байгаа нь хөдөлмөрийн зах зээлд мэргэжлээрээ ажиллах боломж хүрэлцээтэй байгааг харуулж байна. ХНХЯ, хөдөлмөрийн судалгааны институтээс 2020 онд гаргасан хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгааны тайлангаас үзэхэд ажиллах хүчний эрэлт хэрэгцээ 2.9 хувь байгаа нь уг мэргэжил эрэлт хэрэгцээтэй байгааг харуулж байна. Ажил олгогч хамтран ажилладаг байгууллагуудын ажлын байранд тавигддаг шаардлагын хүрээнд судлахад цаг төлөвлөлт, ажил мэргэжлээ системтэйгээр ахиулах, манлайлах, баг ахлах, санаачлах, ажил шийдвэрлэх, өөрийгөө хөгжүүлэх, бичиг баримт боловсруулах зэрэг шалгуурыг чухлаар тодорхойлсон байна.
2. Олон нийтэд таниулах зорилгоор мэргэжил сурталчлах өдөрлөг, сагсан бөмбөгийн тэмцээн, эсээ бичлэгийн уралдаан, цахилгаан техникийн онолын уралдаан, бүтээлийн үзэсгэлэн, энтрепренёр хөтөлбөр зохион байгуулах зэрэг тодорхой ажлуудыг сургууль тэнхимээс төлөвлөн хэрэгжүүлдэг, олон нийтэд таниулан сурталчлах зорилгоор этүгэн их сургуулийн вэб сайт, албан ёсны фейсбүүк хуудас, www.emch.mn, LIKE HD телевизээр цахим сурталчилгаа хийдэг ба жил бүр 21 аймагт багш суралцагсдын хамтарсан баг ажиллаж хөтөлбөрийн онцлог давуу талыг сурталчлан таниулдаг байна. Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй мэдээллийг түгээдэг байна.

Онцлог зүйл/Туршлага:

- Жил бүр 21 аймагт багш суралцагсдын хамтарсан баг ажиллаж хөтөлбөрийн онцлог давуу талыг сурталчлан таниулдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

1. Суралцагчид хөтөлбөрийн талаарх мэдээлэл ил тод байдлыг дараах мэдээллийн эх сурвалжаас хүргэдэг байна. Үүнд: Этүгэн их сургуулийн веб сайт (www.etugen.edu.mn), УМС-student.etugen.edu.mn, суралцагсдын гарын авлага, фэйсбүүк групп, мэргэжлийн хичээлийн блог, багшид хөтөлбөрийн талаарх мэдээлэл ил тод байдлыг дараах мэдээллийн эх сурвалжаас хүргэдэг нь УМС-хариуцлагатай программ teacher.etugen. багшийн гарын авлага, багшийн ажлын дэвтэр, GMAIL etugen.edu.mn.
 - а. Хөтөлбөрийн танилцуулга хөнгөлөлт тэтгэлэг, мэргэжил сонголт, боломж зэрэг агуулга багтаасан элсэгчдэд зориулсан мэдээ, мэдээлэл бүхий сэтгүүл, тараах материалыг жилд 2 удаа тогтмол хэвлэн 6000 гаруйг олон нийтэд нээлттэй хүргэдэг. Багш, оюутны эрдэм шинжилгээний бүтээл, эмхэтгэлийг жил бүр Эрдмийн зул сэтгүүлд сүүлийн 12 жилийн турш хэвлэн олон хийтэд хүргэж байна.
2. Сургуулийн веб хуудас нь жил бүр агуулгын хувьд шинэчлэгдэн сайжирдаг байна. 2021оны 3 сард цахим хаягийн тандалт 50 мянга, хандсан хуудасны тоо 138 мянга, 2019 онд 360 орчим виртуал орчноор аялах контент нэмэгдсэн байна.

Онцлог зүйл/Туршлага: Сургуулийн вэб сайтын мэдээлэлд тогтмол шинэчлэл хийдэг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

1. ЭИС-ийн ректорын 2020 оны 01-р сарын 20-ны өдрийн 26 тоот тушаалаар оюутан элсүүлэх журмыг баталсан ба уг журмаар элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулдаг.
2. ЭТТИ мэргэжлээр суралцагч нарын ЕШ-ын дундаж оноо 498, хүсэлт гаргасан 47 суралцагч 2021-2022 оны хичээлийн жилд элсэн суралцаж байна (ӨҮТ-н 99-100-р хуудас, Зураг 5.1, Хүснэгт 5.1).
3. ЭИС-д суралцагч нар нь оюутны хөтчийг хэвлэмэл ба цахим хэлбэрээр унших боломжтой. Цахим хөтөч нь УМС-д байршсан.
4. Гадаад оюутны элсэлт аваагүй.

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутны хөтөч УМС-д байршиж, суралцагч өөрийн нэвтрэх нэр, кодоор орж судлах боломжтой.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

1. Зөвлөх үйлчилгээний чиглэлээр нийт 22 ажил төлөвлөгдсөнөөс ЭТТИ мэргэжлийн ангид зориулсан 12 ажил хийгдэж байна (ӨҮТ-н 102-р хуудас).
 - a. ЭИС-ийн нийт элсэн суралцагч нарт Халдвар хамгаалал, гэр бүл төлөвлөлт, ханиад томуунаас сэргийлэх, хүний хөгжил, харилцааны ёс зүй гэсэн 5 чиглэлээр зөвлөх, хөгжүүлэх хичээлүүдийг сургуулийн ректор заадаг.
 - b. ЭИС-ийн ректорын 2021 оны 04-р сарын 20-ны өдрийн 33 тоот тушаалаар “Оюутан төгсөгчдийн хөгжлийн хөтөлбөр 2030” баталсан.
2. 2017-2020 хооронд оюутны сэтгэл ханамжийн судалгааг тогтмол хийж, үр дүнгээр эмхэтгэл хэвлэн гаргасан.
3. БСШУЯ-ны дээд боловсролын шинэчлэл төслийн хүрээнд “Оюутны санаачилгыг дэмжих төсөл”-ийн уралдаанд ЭТТИ мэргэжлээр суралцаж буй нийт 6 оюутны 2 баг оролцож, 3 сая төгрөгийн санхүүжилт авсан. ЭИС-ийн нийт элсэн суралцагч нарт Халдвар хамгаалал, гэр бүл төлөвлөлт, ханиад томуунаас сэргийлэх, хүний хөгжил, харилцааны ёс зүй гэсэн 5 чиглэлээр зөвлөх, хөгжүүлэх хичээлүүдийг сургуулийн ректор заадаг
4. 2008 оноос хойш зохион байгуулагдсан “Эрдмийн зул” оюутны эрдэм шинжилгээний хуралд 2016-2020 оны хооронд нийт 35 ЭТТИ мэргэжлээр суралцаж буй оюутнууд оролцсон байна (ӨҮТ-н 113-р хуудас).

Онцлог зүйл/Туршлага:

- 2019-2020 оны хичээлийн жилээс “Хүн байхуй” хичээлийн хөтөлбөрийн хүрээнд ЭИС-ийн нийт багш, ажилтан, суралцагч нар “ Өглөөний хүн, эртэч шувуухай” хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.
- МУ-ын Оюуны Өмчийн Газрын Даргын 2021 оны 06-р сарын 24-ны өдрийн А/63 тоот тушаалаар “Хүний хөгжил, харилцааны ёс зүй” хичээлийн хөтөлбөр №12978 тоот зохиогчийн эрхийн гэрчилгээ авсан. Мөн “Энтрепрёнер”, “Эмнэлзүйн хиймэл оюун ухааны үндэс” хичээлийн хөтөлбөрүүд зохиогчийн эрхийн гэрчилгээтэй.
- Оюутны хөгжлийн чиглэлээр IDEA-Энтрепенёр судалгааны төв, усан бассейн, мини кино театр, сэтгэлзүйн зөвлөгөө өгөх төвийг байгуулж, ашиглалтад оруулсан.
- Оюутны сургалтын вэб буюу УМС-д сүүлийн 3 жилд шинэчлэл хийж, сургалтын төлбөр төлөлтийг e-barimt системтэй холбосон, суралцагч ТҮЦ машинаас дүн, оюутны тодорхойлолт авдаг байсныг УМС-н системээр дамжин авдаг болсон, өргөдөл хүсэлтийг холбогдох алба, газарт илгээх боломжтой болгож сайжруулсан.

Зөвлөмж:

- ЭТТИ мэргэжлээр суралцаж буй оюутнуудад зориулсан мэргэжлийн сонгон хичээл, дугуйлангийн тоог нэмэгдүүлэх.
- Гадаадын их дээд сургуулиудтай хамтарсан оюутан солилцооны хөтөлбөрүүд хэрэгжүүлэх ажлуудыг өргөтгөх, гадаад харилцааны төрөл бүрийн төслүүдийг цаашид өргөтгөх.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

1. ЭИС-ийн хэмжээнд сайн дурын 19 оюутны клуб ажиллаж байна. Эдгээр клубүүдийн тасралгүй үйл ажиллагаа явуулдаг (ӨҮТ-н 111-112-р хуудас).
2. Суралцагчийн гүйцэтгэсэн сайн дурын ажлууд хийж гүйцэтгэдэг. Тухайлбал цусны төвтэй хамтарсан цус хандивлах аян зохион байгуулсан. Мөн ковидын оношлуурууд хандивласан (ӨҮТ-н 112-р хуудас).
3. Цагийн болон үндсэн ажилд зуучилсан оюутны судалгааг хийсэн байна (ӨҮТ-н 114-р хуудас). ЭТТИ мэргэжлийн төгсөлтийн шалгалтанд ажил олгогч нарын төлөөллийг урьж оролцуулан, нийт 22 төгсөгчийг ажлын байранд зуучилсан байна.
4. ЭИС-ийн ректорын 2021 оны 04-р сарын 20-ны өдрийн 33 тоот тушаалаар “Оюутан төгсөгчдийн хөгжлийн хөтөлбөр 2030” баталсан. Уг хөтөлбөрт 3 зорилтын хүрээнд 24 ажил хийхээр төлөвлөсөн. 2018 оноос ЭИС-ийн инженерчлэлийн тэнхим “цахилгаан техникийн онол” хичээлээр ЭТТИ мэргэжлээр суралцагч нарын дунд олимпиад зохион байгуулсан.
5. Тусгай хэрэгцээт 50 гаруй оюутан байгаагаас “Этүгэн сан”-с сургалтын тэтгэлэг, сургалтын төлбөрийн зээл зэрэгт хамруулсан.

- a. Урлаг, спортын амжилт гаргасан болон санхүүгийн дэмжлэг шаардлагатай оюутнуудын 43.5 сая төгрөгийн сургалтын төлбөрийг төлсөн. Боловсролын сангийн зээлд 155 ЭТТИ мэргэжлээр суралцагсад хамрагдаж, 30 сая 232 мянган төгрөгийн тэтгэлэг авсан.
- b. Этүгэн энтрепренёр хөтөлбөрийг хэрэгжүүлж, инновацийн төслүүдийг шалгаруулж, 63 суралцагч нийт 14 сая төгрөгийн гарааны бизнесийн санхүүжилтийг авсан. ЭТТИ мэргэжлээр суралцаж буй оюутнуудаас дээрх төсөлд 86 оюутан оролцсон.

Онцлог зүйл/Туршлага:

- “Этүгэн ирвэсүүд” гар бөмбөг, сагсан бөмбөгийн шигшээ багуудтай, бэлтгэлийн заал, хурлын заал зэргийг тохижуулсан.

Зөвлөмж:

- ЭТТИ мэргэжлээр суралцаж буй оюутнуудын клубийг байгуулах, үйл ажиллагаанд шаардагдах төсвийг батлах.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

1. ЭИС-ийн ректорын 2018 оны 10-р сарын 25-ны өдрийн 102 тоот тушаалаар баталсан “Сургалтын нэгдсэн журам”-ын 6.5, 6.8, 9.4, 9.5 заалтаар багц цагийн дүйцэл, шилжилт хөдөлгөөний үйл ажиллагааг зохицуулдаг. Шилжилт хөдөлгөөнийг журмын дагуу улирал бүрд шийдвэрлэдэг. Сүүлийн 5 жилд ЭТТИ мэргэжлээр суралцагсдаас жилийн чөлөөнөөс орсон 26, дотоодын бусад их дээд сургуулиас шилжиж ирсэн 17, хангалтгүй суралцаж, жил өнжсөн 24 суралцагч байна.
2. Багц цагийн дүйцэл, шилжилт хөдөлгөөний дүрэм журмыг “Сургалтын нэгдсэн журам”-аар зохицуулдаг.

Онцлог зүйл/Туршлага:

- Багц цагийн дүйцүүлэн тооцохдоо судалсан гадаад хэл, компьютерын хичээлийг ур чадварын шалгалтаар зохион байгуулж, түвшин тогтоож, түвшний ангилалд тохирсон дээрх хичээлүүдийг сонгон судалдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

1. БСШУ-ны сайдын 2012 оны 303 тоот тушаал, ЭИС-ийн ректорын 2018 оны 10-р сарын 25-ны өдрийн 102 тоот тушаалаар баталсан “Сургалтын нэгдсэн журам”-ын 7.9-р заалтын дагуу төгсөлтийн хяналтын комиссыг байгуулан ажилладаг. Баримт бичгийг журамд заасан байдаг (ӨҮТ-н 118-р хуудас).

2. 2015-2020 оны хооронд ЭТТИ мэргэжлээр нийт 124 суралцагч төгссөн байна. Дүрэм журмын хэрэгжилтийн байдлыг ӨҮТ-н 119-р хуудаст тусгасан байна.

Онцлог зүйл/Туршлага:

1. Төгсөлтийн баримт бичиг олгох үйл ажиллагааны хяналтын явцад төгсөлтийн шалгалтын комиссоос гадна оюутан өөрөө оролцож, дүнгийн тулгалт хийдэг байна.
2. Цар тахалтай холбоотойгоор сүүлийн 2 жилд төгсөгч нарын диплом, энгэрийн тэмдгийг “Монгол шуудан” ХХК-тай хамтран баталгаат шуудангаар төгсөгч нарын оршин суугаа газрын хаягаар хүргүүлсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилгоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

1. 2018 оны 10 сарын 25-ны өдрийн 102 тоот тушаалаар батлагдсан хөдөлмөрийн дотоод журам, хөгжлийн стратеги, ЭИС-н дүрэм, сургалтын нэгдсэн журам, багшийн хөгжил хөтөлбөр, МУ-н хөдөлмөрийн хууль, холбогдох тогтоомжийн дагуу, тухайн ажлын байрны тодорхойлолтын дагуу, хувь хүнтэй хийсэн 3 хавсралт бүхий хөдөлмөрийн гэрээгээр багш нар ажилладаг байна. Багшийн шалгаруулалтад оролцогчдод тавигдах шаардлага, бүрдүүлэх материал зэрэг нь сургалтын нэгдсэн журмын 11.12, 11.13 хэсэгт заагдсан байдаг.
2. Хөтөлбөр хэрэгжүүлэгч хүний нөөцийн хувьд нийт 32 багш, үүнээс докторын зэрэгтэй багшийн эзлэх хувь 31% байна. Докторантурт суралцаж буй багш 8 буюу 25%-г эзэлж байна. (Докторын зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жингийн судалгаа хийсэн байна. Хавсралт 6.1)
3. Мөн өөрийн үнэлгээний тайлангийн 6.1.3 хэсэгт багш, суралцагчдын тооны харьцааны судалгааг гүйцэтгэсэн байна. Инженерчлэлийн тэнхимийн хувьд 1:5.9 гэсэн харьцаатай байна.
4. Сургалтын нэгдсэн журмын 11.16-д багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагуудыг заасан байна. Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагыг мөрддөг байдлын судалгааг өөрийн үнэлгээний тайлангийн 6.1.4-т тайлбарласан. 2020 оны байдлаар дадлагажигч багш 1, багш 9, ахлах багш 11, дэд профессор 2, профессор 9, нийт 32 байна.
5. Багшийн цагийн ачаалал нь сургалтын үйл ажиллагаа (А), эрдэм шинжилгээ төсөлт ажил (Б) гэсэн хоёр чиглэлээр тодорхойлогддог. Багшийн цагийн ачааллыг сүүлийн гурван жилээр тооцсон байна. Дунджаар 22.06 байна. (ӨҮТ-н Зураг 6.3, 126-р хуудас)
6. Мөн багш нарт олгосон урамшууллын судалгааг Хүснэгт 6.5 болон 6.6-д харуулсан байна. ЭИС-н хувьд гүйцэтгэлийн болон чанарын үнэлгээнд суурилан багш нарыг урамшуулдаг байна.

Зөвлөмж:

1. Докторыг зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жинг нэмэгдүүлэх
2. Нийт 32 багшаас профессорын албан тушаал дээр 9 хүн ажиллаж байна. Албан тушаалын зэрэглэлийн харьцаа дээр анхаарах.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

1. Жил тутам багшийн хөгжлийн хэрэгцээний судалгааг авч, тухайн салбарын үндэсний болон олон улсын мэргэжилтэн судлаачдыг урьж сургалтын үйл ажиллагаа явуулдаг байна (ӨҮТ-н 128-131-р хуудас).
2. Хичээлийн жилийн төгсгөлд бүрэлдэхүүн сургууль, тэнхим, багш нарын сургалтын санал авч багшийн хөгжлийн сургалт үйл ажиллагааны төлөвлөлт гарган (Хүснэгт 6.7-д төлөвлөлтийг заасан) ажилладаг байна. Мөн багш бүр өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөө гарган ажилдаг.
3. Гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлсэн, сургалтад хамрагдсан байдлын судалгааг 2016-2020 оны байдлаар судалж гаргасан (ӨҮТ-н 133-р хуудас, Хүснэгт 6.13).

Онцлог зүйл/Туршлага:

- Багш, оюутны хөгжил, мэдээлэл солилцох, асуудал шийдвэрлэх зорилгоор “Өглөөний хүн, эртэч шувуухай” хөтөлбөр хэрэгжүүлдэг.

Зөвлөмж:

- Мэргэжлийн багш нар мэргэжлийн сургалтад бага хамрагддаг. Нарийн мэргэжлийн мэргэжил дээшлүүлэх сургалтуудад хамруулах.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

1. Тухайн хөтөлбөрийн багш нар өөрсдийн мэргэшсэн чиглэлээр судалгааны төсөлд ажлууд дээр үндэсний болон олон улсын судлаачдын багуудтай хамтран ажилладаг байна. ЭИС-с судалгааны тэргүүлэх чиглэл, цөм технологийн жагсаалтыг 2018 онд гаргасан байна (Өөрийн үнэлгээний тайлангийн 134-р хуудас). Багш нарын эрдэм шинжилгээний бүтээлийн жагсаалтын товчоог Хүснэгт 6.15-д харуулсан байна.
2. ЭИХ-н хөгжлийн стратеги: 2030 баримт бичигт 12 зорилтын хүрээнд 20 үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон. Эрдэм шинжилгээ, судалгаатай холбоотой дүрэм журам багшийн мэдээллийн системийн мэдээ мэдээлэл хэсэгт дээр, сургалтын нэгдсэн журмын эмхэтгэл дээр зааж тусгасан байна.
3. Зарим судалгааны үр дүнг хөтөлбөрийн сайжруулалтад ашигласан байдлыг Хүснэгт 6.16-д жишээ болгон харуулсан байна.
4. ӨҮТ-н Хүснэгт 6.17-д хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нарын эрдэм шинжилгээний бүтээл, судалгааны ажлын нэгтгэлийг 2016-2020 оны хооронд хийж, нэгтгэсэн байна.
5. Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зарцуулсан төсөв, гүйцэтгэлийг сүүлийн 4 жилээр Хүснэгт 6.18-д харуулсан байна. Эндээс харахад энэ төрлийн зарцуулалт өссөн дүнтэй байгаа нь харагдаж байна.

Онцлог зүйл/Туршлага:

- Эрдэм шинжилгээ, инновацийн хөгжлийг дэмжих арга хэмжээ зохион байгуулдаг. 10 чиглэлээр судалгааны ажлуудын гэрээ хийгдсэн. Гарааны бизнесийн төсөл шалгаруулж, хөрөнгө оруулалт татдаг. Уламжлалт эм тан бүхий гоо сайхны бүтээгдэхүүн хийх гарааны компани байгуулан ажиллаж байгаа.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн мэргэжлийн багш нар мэргэжлийн сурах бичиг бичих тал дээр анхаарах. Дэмжлэг үзүүлэх бодлого баримтлах.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

1. Багшийн ажлын үнэлгээ нь нээлттэй, бодитой байх зарчим баримтлан, тэдний бүтээлч үйл ажиллагааг дэмжих, хөгжүүлэх зорилгоор явагддаг байна.
 - a. Багш бүр 5 чиглэлийн дагуу ажлаа төлөвлөж, хэрэгжүүлж, улирал бүрийн төгсгөлд өөрийн үнэлгээнд суурилан үнэлэгддэг байна. УМС-д багш бүрийн ажлын төлөвлөлт, гүйцэтгэл байршдаг байна.
 - b. Багшийн төлөвлөлтийн дагуух ажлын гүйцэтгэлийн тайланг хөтөлбөрийн дэд болон ерөнхий хороо, СБЗА-нд танилцуулагддаг. Хөтөлбөрийн дэд болон ерөнхий хороо, СБЗА өөрийн үнэлгээний тайлангийн гүйцэтгэлд хөндлөнгийн үнэлгээ хийж, гүйцэтгэлд суурилсан урамшууллыг улирлын туршид үндсэн цалин дээр нэмэлтээр олгодог. (Нотлох барим 6.4.1.1)
 - c. Багшийн хөндлөнгийн үнэлгээг мөн суралцагч, оюутнуудаас авдаг.
 - d. Багш бүр багшийн ажлын хавтас хөтөлдөг юм байна.
2. Сүүлийн 4 жилийн дунджаар нийт багш нарын ээлжит хичээлийн өөрийн үнэлгээний дундаж 84.4 хувь байна. (Нотлох барим 6.4.2.2)
3. Багшийн үйл ажиллагаанд хөндлөнгийн үнэлгээг удирдлага, багш, суралцагчдын түвшинд тогтмол хийж, дүгнэлт гаргаж, зөвлөн тусалдаг. Сүүлийн гурван жилийн судалгааны дүнгээс харахад багшийн хөндлөнгийн үнэлгээ 94 хувьтай байна (ӨҮТ-н 140-р хуудас).
4. Багшийн үнэлгээний дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээг Хүснэгт 6.22-д харуулсан. Мөн багшийн үйл ажиллагааны баримт материалын бүрдүүлэлтийг Хүснэгт 6.23-т харуулсан байна. Ингэснээр тасралтгүй сайжруулалт хийх боломж бүрдэж байна.
5. Багшийн ажлын хавтсыг Хавсралт 6.3-т харуулсны дагуу хөтөлж байнга сайжруулалт хийдэг. Багшийн ажлын дэвтрийн үнэлгээ 92.3 хувьтай гэж удирдлагын зүгээс дүгнэсэн байна (ӨҮТ-н 140-р хуудас).

Онцлог зүйл/Туршлага:

- Багш нарын ажлын гүйцэтгэлийг үнэлж цалингийн урамшуулал олгохоос гадна урамшууллын мөнгөн хадгаламж үүсгэж 5 жил тутам авах боломжоор хангадаг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажуулалт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн чанарын дотоод баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

1. Сургалтын хөтөлбөр нь сургууль, тэнхимүүдийн төлөөлөл бүхий 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр тогтмол үйл ажиллагаагаар дамжуулан сургалтын хөтөлбөр боловсруулах, сайжруулах, хэрэгжүүлэх, өөрийн үнэлгээ хийх чанарын удирдлагын схемтэй. ӨҮТ-н Зураг 7.2-т харуулсанчлан чанарын багийн ахлагчаар 2019 оноос хойш ажиллаж байгаа М.Баярбилэг, дотоод хяналт, мониторинг хариуцсан Амгаландарь-төгсөгч хариуцсан менежер, сургалтын бодлого зохицуулалтын албаны дарга Мөнгөнцэцэг нар байна. Хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажилтыг хангахын тулд үнэлгээ судалгаа хийх, олон улсын болон БМИҮЗ-ийн шалгуурын дагуу өөрийн үнэлгээ хийхээс гадна чанарын удирдлагын тогтолцооны олон улсын ISO 21001:2018 стандартыг хэрэгжүүлэх бэлтгэл хангах зорилгоор үе шаттай сургалтыг зохион байгуулсан байна.
2. Сургалтын нэгдсэн журмын 12-р бүлэгт чанарын дотоод баталгаажуулалтын үйл явц, хяналт, үнэлгээг тусгасан байна. Тус сургуулийн чанарын менежментийн тогтолцоонд эрхэм зорилго, алсын хараа, стратеги төлөвлөгөөнд тулгуурлаж сургалтын үйл явцыг удирдан зохион байгуулахдаа тодорхой схемийн дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт, сайжруулалт тасралтгүй хөгжүүлэх менежментийн дагуу зохион байгуулж, чанарын хяналт хийхдээ Этүгэн сургуулийн дүрэм, сургалтын нэгдсэн журам, хөтөлбөрийг боловсруулах, сайжруулах, хэрэгжүүлэх бодлого чиглэл, номын сангийн журам, байгууллагын нууцын журмыг баримтлан ажилладаг, мөн сургалтын үйл ажиллагааг нотолгоонд суурилан сайжруулж, өдөр тутмын үйл ажиллагаанд дотоод хяналт, мониторинг хариуцсан мэргэжилтэн хяналт тавьж ажилладаг байна (ӨҮТ-н 148-152-р хуудас).
3. Ректорын тушаалаар батлагдсан хөтөлбөрийн ерөнхий хороо нь 7 хоног бүр төлөвлөлтийн дагуу хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээний тайланг хэлэлцэж, өөрийн үнэлгээнд суурилан сургалтын хөтөлбөр боловсруулах, сайжруулах, хэрэгжүүлэх явцын үнэлгээ, дүгнэлт, зөвлөмжийн дагуу үе шаттай үнэлгээ хийгдсэн байна.
 - а. Элсэгчдийн түвшинд ЭЕШ онооны хамаарал, сэтгэл ханамж, хичээл нэг бүрийн үнэлгээ, сурлагын амжилт, төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаануудыг 2017 оноос эхлэн тогтсон хугацаанд авч боловсруулалт хийж 3 удаагийн товхимол хэвлэгдсэн, багшийн хичээлийн өөрийн үнэлгээ, сэтгэл ханамж, сургалтын амжилт, чанар зэргийг харгалзан ажлыг үнэлдэг, ажил олгогчоос авах сэтгэл ханамжийн судалгаануудын үр дүн нь чанарын дотоод баталгаажуулалтын хэрэгжилт явагдаж үнэлдэг гол шалгуур болдог байна.

- б. Хөтөлбөрийн оролцогч талууд болох сургуулийн удирдлага, багш, элсэгч, суралцагч, төгсөгч, ажил олгогч, хамтран ажиллагч байгууллагаас хөтөлбөрийн үр дүнг агуулсан судалгаа санал асуулгыг төлөвлөлт хуваарийн дагуу зохион байгуулж, үр дүнд анализ дүгнэлт хийж, үйл ажиллагаандаа тусган олон нийтэд хүргэж байна. Санал асуулгыг нэгтгэн дүгнэж, сургалтын хөтөлбөрийг улам боловсронгуй болгон, багш нарыг чадавхжуулах, оюутны хөгжил, сургалтын агуулга, хэрэглэгдэхүүн, сургалтын зохион байгуулалт, орчны тохижилт үйлчилгээ зэрэгт төсөв, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахдаа тусгайлан авч үздэг байна.

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн ерөнхий хороо нь 7 хоног бүр төлөвлөлтийн дагуу хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээний тайланг хэлэлцэж, өөрийн үнэлгээнд суурилан сургалтын хөтөлбөр боловсруулах, сайжруулах, хэрэгжүүлэх явцын үнэлгээ, дүгнэлт, зөвлөмжийн дагуу үе шаттай үнэлгээ хийгдсэн байна. Хөтөлбөрийн оролцогч талууд болох сургуулийн удирдлага, багш, элсэгч, суралцагч, төгсөгч, ажил олгогч, хамтран ажиллагч байгууллагаас хөтөлбөрийн үр дүнг агуулсан судалгаа санал асуулгыг төлөвлөлт хуваарийн дагуу зохион байгуулж, үр дүнд анализ дүгнэлт хийж, үйл ажиллагаандаа тусган олон нийтэд хүргэж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

Илрэл нотолгоо:

1. Төгсөгчдийн ажил эрхлэлтийн байдал, ур чадварын нийцэл, ажилгүй байгаа шалтгаан, ажлын байрны шаардлагад төгсөгчдийн ур чадвар хэрхэн нийцэж байгаа байдал, хөдөлмөр эрхлэлтэд тулгарч буй хүндрэл бэрхшээлийг тодорхойлсноор цаашид хөтөлбөр, сургалт үйл ажиллагааны чанарыг хөгжүүлэхэд тусган ажиллаж байна. 2014-2020 он хүртэл 169 төгсөгчдөөс 140 хүнд судалгаа хийхэд ажил эрхлэлтийн түвшин 93 хувьтай, хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн 61 хувь мэргэжлээрээ, 39 хувь нь мэргэжлийн бус /техникч/ байна.
2. Үндсэн хөтөлбөр хэрэгжүүлэгч тэнхим нь ЭТТИ хөтөлбөрөөр төгсөгчдийн ажил эрхлэлт, төгсөлтийн дараах сургалт, карьерын өсөлтийг байнга судалж эргэх холбоотой ажиллаж байна. Үүнд: төгсөгчдийн карьерын судалгаанд хамрагдсан 92 төгсөгчийн 5,4 хувь нь магистрантур, докторантурын сургалтанд хамрагдсан түүний 60 хувь нь гадаадын их сургуульд суралцаж байна.
3. 2019-2020 онд төгсөгчдийн ажилд орсон хугацааг харвал 31.9 хувь нь төгсөхдөө ажлын байртай болсон, төгсөөд 3 сарын дараа 21 хувь, 4-6 сарын дараа 10,5 хувь, 7-9 сарын дараа 5 хувь гээд нийт төгсөгчдийн 68,3 хувь нь ажилд орсон байна.
4. Оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгааны дүнгээс харахад мэргэжилтний мэдлэг, ур чадварыг сайн, маш сайн гэж үнэлсэн ажил олгогчдын 65 хувь байсан

бол хөтөлбөрийн үр дүн болох 19 ур чадварыг 76,5 хувь нь өндөр ач холбогдолтой гэж үзсэн нь хөтөлбөрийн чанар, үр дүнгийн нийцэл хангалтай сайн гэж үзлээ.

- a. Элсэгчдийн сэтгэл ханамжийн судалгаагаар 96 хувь нь ханамжтай, суралцагчдын сэтгэл ханамж эхний жил 10 хувь байснаа жилээс жилд өсч 50 хувьтай байгаа нь хөтөлбөр сайжруулалт, менежментийн тогтолцоо тасралтгүй сайжирсантай холбоотой. Мөн сургалтын чанар үйл ажиллагааны талаарх төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаанд төгсөөд мэргэжлээрээ ажиллана гэсэн 89-91 хувь нь хариулсан бол үнэлгээний систем сэтгэл ханамжтай гэж 53-56 хувь, багш нарын мэдлэг, чадвар, хандлагыг 63-69 хувь болон өссөн нь 2019, 2020 оны судалгаанаас харагдаж байна.
 - b. Төгсөгчид сургалтын үр дүнг “сэтгэл ханамжтай” гэж 2018-2019 онд 83 хувь байсан бол 2019-2020 онд 74 хувь болсон нь хөтөлбөрийн үр дүн, ур чадварын эзэмшилтэд сэтгэл хангалуун байгаагийн илрэл, төдийгүй хөтөлбөрийн тасралтгүй сайжруулалт, суралцагчдын хүлээлт, бодит байдалд нийцтэй байгааг тодорхойлж байна. Судалгааны үр дүнгээс харахад 2019, 2020 онд сэтгэл ханамжийн дундаж 73-76.5 хувь болж 3.6 хувиар буурсан нь цар тахлын үед сургалт сургалтын үйл ажиллагаа цахим хэлбэрт шилжсэнтэй гэж таамаглан улам нарийвчлан судлах хэрэгтэй гэж үзэж байна.
5. Хөтөлбөрийн үр дүнгийн судалгаа хийж, үр дүнг хөтөлбөртөө тусгасан байна (ӨҮТ-н 159-160-р хуудас).

Онцлог зүйл/Туршлага:

- Багш, элсэгч, суралцагч, төгсөгч, ажил олгогч, хамтран ажиллагч байгууллагаас сэтгэл ханамжийн судалгаа, санал асуулгыг хуваарийн дагуу тогтмол зохион байгуулж, үр дүнд анализ, дүгнэлт хийн, үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, хэвлэн олон нийтэд түгээдэг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

1. Этүгэн их сургууль сургалтын чанарыг дээшлүүлэх бодлогыг тасралтгүй хэрэгжүүлж, 2012 онд БСШУЯ-аар аттестатчилагдаж, Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөр ахисан түвшинд магадлан итгэмжлэгдсэн. 2014 онд АНУ-ын ACBSP бизнесийн сургууль хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн зөвлөлөөр бизнесийн удирдлагын сургалтын 5 хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлсэн. БМИҮЗ-ийн хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлагын дагуу өөрийн үнэлгээ хийсэн.
2. Үндсэн хөтөлбөр хэрэгжүүлэгч тэнхим нь ЭТТИ хөтөлбөрөөр төгсөгчдийн ажил эрхлэлт, төгсөлтийн дараах сургалт, карьерын өсөлтийг байнга судалж эргэх холбоотой ажиллаж байна. Үүнд: төгсөгчдийн карьерын судалгаанд хамрагдсан 92 төгсөгчийн 5,4 хувь нь магистрантур, докторантурын сургалтанд хамрагдсан

түүний 60 хувь нь гадаадын их сургуульд суралцаж байна. Мэргэжил дээшлүүлж мэргэшсэн байдлыг харвал 15 хувь нь мэргэжлийн зэргээ ахиулж, 9,7 хувь нь хүн удирдах, өөрөө ханган нийлүүлэх компани байгуулсан, ахлах инженер зэрэг ажил эрхэлж байна.

3. Өөрийн салбарын мэргэжлийн холбоодтой хамтран ажиллаж хөндлөнгийн баталгаажилтыг хийлгэсэн байна. Үүнд: 1999 онд Монголын эмнэлгийн инженерчлэлийн нийгэмлэг байгуулагдсан, 2009 онд Дэлхийн эмнэлгийн инженерчлэлийн нийгэмлэгийн гишүүн орон болсноор дэлхий нийтийн техник технологийн салбарын бодлого чиглэл, үйл ажиллагааны сайн туршлага хуваалцах, хамтран ажиллах боломж бүрдсэн чухал ач холбогдолтой. (ӨҮТ-н 162-р хуудас).

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ДҮГНЭЛТ

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Үндэслэл, шалтгаан /х/х, хангаагүй дэд шалгуур байвал үндэслэлийг тодорхой бичнэ./
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	3		
2	Сургалтын үйл ажиллагаа	3		
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	2	1	3.1. Хөтөлбөрийн зорилго, зорилгод нийцэх электроникийн лабораторийн орчин үеийн тоног төхөөрөмж байхгүй, эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэргэшүүлэх хичээлийн лаборатори байхгүй.
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	4	1	4.2. Анхны төгсөлт хийснээс хойш 7 жил өнгөрсөн боловч богино хугацааны болон мэргэшүүлэх сургалтуудыг тогтмол явуулаагүй.
5	Суралцагчид чиглэсэн үйл	5		
6	Багшийн үйл ажиллагаа	4		
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	3		

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Этүгэн их сургуулийн “Үйлдвэрлэлийн автоматжуулалт” (Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер) бакалаврын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “Бүрэн хангасан” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг БМИҮЗ-ийн Инженерчлэл, үйлдвэлэл, зохион бүтээлтийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

Шалгуур	Зөвлөмж
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> - Нийгэм, эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг харуулсан шинжилгээг илүү нарийвчлан хийх (STEER шинжилгээ хийх), судалгааны эх сурвалжуудыг сүүлийн үеийн өгөгдөл ашиглаж гүйцэтгэх; - Олон улсын түвшинд адил төстэй мэргэжилтэн бэлтгэдэг сургуулиудын судалгааг дэлхийн нэр хүндтэй их сургуулиудтай харьцуулан өргөтгөж гүйцэтгэх. Тухайлбал Америк, Европын их сургуулиудтай харьцуулж болох юм.
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> - Дадлагын гэрээнд эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер мэргэжлийн үйл ажиллагааны чиглэлийг зааж өгөх, одоогийн байгаа гэрээ нь нийтлэг байдлаар хийгдсэн учир нарийвчлан тусгах; - Сургалтын төлөвлөгөөнд оюутнуудын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх, ажлын байран дээр ажиллах үед шаардлагатай чиглэлээр мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээлийн нэр төрөл, багц цагийг нэмэгдүүлэн тусгах. Оюутны суралцах хэлбэр дээр практик туршилтууд түлхүү оруулах, эмнэлэг, ханган нийлүүлэх компаниуд дээр очиж дадлагын хичээл хийх боломжийг хангах;
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Эрдэм шинжилгээний бүтээл, сэтгүүл, бусад эх сурвалжууд руу багш, оюутан хандаж унших боломжтой төлбөртэй эх сурвалжуудыг ашиглах судалгаа хийж, нэвтрүүлэх;
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> - Төгсөгчдийг урт, богино хугацааны давтан сургалтад тогтмол хамруулах; Төгсөлтийн дараах сургалтын систем шаардлагатай.
Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> - Хөтөлбөрөөр суралцаж буй оюутнуудад зориулсан мэргэжлийн сонгон хичээл, дугуйлангийн тоог нэмэгдүүлэх; - Гадаадын их дээд сургуулиудтай хамтарсан оюутан солилцооны хөтөлбөрүүд хэрэгжүүлэх ажлуудыг өргөтгөх, гадаад харилцааны төрөл бүрийн төслүүдийг цаашид өргөтгөх; - Хөтөлбөрөөр суралцаж буй оюутнуудын клубийг байгуулах, үйл ажиллагаанд шаардагдах төсвийг батлах;
Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> - Докторын зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жинг нэмэгдүүлэх; - Нийт 32 багшаас профессорын албан тушаал дээр 9 хүн ажиллаж байна. Албан тушаалын зэрэглэлийн харьцаа дээр анхаарах; - Мэргэжлийн багш нарыг нарийн мэргэжлийн мэргэжил дээшлүүлэх сургалтуудад хамруулах; - Хөтөлбөрийн мэргэжлийн багш нар мэргэжлийн сурах бичиг бичих тал дээр анхаарах. Дэмжлэг үзүүлэх бодлого баримтлах;
Шалгуур	Шаардлага
Шаардлага 3.1.	<ul style="list-style-type: none"> - Электроникийн лабораторийн тоног төхөөрөмжид шинэчлэлт хийх. Хөтөлбөрийн зорилго, зорилтод нийцсэн туршилт хийх боломж бүхий тоног төхөөрөмжүүдийг

	<p>сонгож шинэчлэлт хийх;</p> <ul style="list-style-type: none"> - Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэргэшүүлэх хичээлийн лаборатори байгуулах шаардлагатай. Тухайн мэргэшсэн чиглэл, сонгон суралцах хичээлүүдийн туршилт, дадлага явагдах боломжийг хангах;
Шаардлага 4.2.	<ul style="list-style-type: none"> - Хөтөлбөрөөр суралцаж төгссөн төгсөгчдийг богино хугацааны давтан сургалт, магистрантурын сургалтад тогтмол хамруулах;

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг:

/Б.Бат-Эрдэнэ/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг:

/Ц.Мягмарнаран/

/Р.Эрдэнэчимэг/

V. Уулзалт ярилцлагад оролцогчдын бүртгэл

I. Багш нартай хийх уулзалт

№	Овог, нэр	Албан тушаал	Утас	Мэйл хаяг
1	М.Туул	Профессор	89115615	tuul.m@etugen.edu.mn
2	Б.Энхжаргал	Профессор	91915920	enhjargal.b@etugen.edu.mn
3	Д.Амгаланзаяа	Ахлах багш	86062666	amgalanzaya.d@etugen.edu.mn
4	Б.Батцэцэг	Ахлах багш	99221400	battsetseg.b@etugen.edu.mn
5	Т.Адьяасүрэн	Багш	99025194	adiyasuren.t@etugen.edu.mn
6	З.Батбаяр	Ахлах багш	80081874	batbayar.z@etugen.edu.mn
7	Ц.Жавзандулам	Багш	99814015	jawzandulam.ts@etugen.edu.mn
8	Т.Соёлмаа	Ахлах багш	99988512	soyolmaa.t@etugen.edu.mn
9	Ц.Ундармаа	Ахлах багш	99031729	undarmaa.ts@etugen.edu.mn
10	Б.Мөнхтуяа	Багш	88635123	munkhtuya.b@etugen.edu.mn

II. Оюутнуудтай хийх уулзалт

№	Овог, нэр	Хэддүгээр курс	Утас	Мэйл хаяг
1	Г.Батсайхан	101	99268975	Batsaihangalt88@gmail.com
2	Т.Сүхбат	101	99364558	Tumurbaatarsuhbat7@gmail.com
3	Б.Ганбат	102	99563231	Batзориганбат71@gmail.com
4	А.Балдансүрэн	102	86868812	baldansurena@gmail.com
5	Г.Жавхлантагс	201	89663370	Ga.javkhlantugs@gmail.com
6	Э.Должидмаа	201	88274749	doojkoe@gmail.com
7	Э.Хатансайхан	201	80871898	Hhatna15@gmail.com
8	Н.Даваабаатар	201	85352554	Ndavaabaatar01@gmail.com
9	Э.Билгүүндалай	301	85152929	Bbek041117@gmail.com
10	С.Бодьсанаа	301	99813877	bodisanaa@yahoo.com
11	Э.Бямбадорж	301	96877774	byambadorjbabu@gmail.com
12	Б.Лхагваболд	301	94361889	Lhagvaboldjbch2@gmail.com
13	Э.Батхуяг	402	88591247	Enkhjargal.bathuyg@gmail.com
14	Т.Бямбасүрэн	401	89365258	Babal.byambaa@gmail.com
15	Б.Болортуяа	402	86842121	Blr442549@gmail.com
16	Б.Далайцэрэн	402	85790824	Dalaitseren0628@gmail.com
17	Г.Эрдэнэ-Очир	402	99622243	aquaerka@gmail.com
18	А.Шүрэн-Эрдэнэ	401	98802885	Ashvree24@gmail.com
19	М.Мөнхжаргал	401	98701292	Mnhjrgl0702@gmail.com
20	Г.Батбямба	401	95245664	Batbyamba5664@gmail.com
21	Б.Энхтулга	401	85140004	Tulga146@gmail.com
22	А.Отгонбаяр	401	86490047	a.otgonbayr336@gmail.com

III. Ажил олгогчидтой хийх уулзалт

№	Овог, нэр	Албан тушаал	Утас	Мэйл хаяг
1	Н. Буянбадрах	Медбуян ХХК Ерөнхий захирал	99153144	buyanaa@medbuyan.mn
2	Г.Цэнгэл	УШТЭ, Тоног төхөөрөмжийн албаны дарга	99759905	Tsengel.gurbadam@gmail.com
3	П.Буяндэлгэр	Хөгжлийн төв – Эмнэлгийн тоног	99103457	P.Buyandelger@mmra.gov.mn

		төхөөрөмжийн газар, Албаны дарга		
4	Б.Ганбаяр	Мажик мед ХХК, Гүйцэтгэх захирал	99112179	Ganbayar@magicmed.mn
5	К. Олжас	Evergreen ХХК, Гүйцэтгэх захирал	99509839	oljas@magicmed.mn
6	С.Зоригоо	Космос тек ХХК Ерөнхий захирал	99267118	Ceo@cosmostech.mn
7	М.Мөнхбаатар	Космос тек ХХК Орлогч захирал	88033055	Buya.ctm@outlook.com
8	Д.Дуламсүрэн	Архангайн нэгдсэн эмнэлэг, Тоног төхөөрөмжийн албаны дарга	99333299	Dulamsuren0826@gmail.com
9	Р.Даваасүрэн	Сетунари, Техникийн албаны дарга	99057823	Davaasuren.r@setunari.com
10	Б.Хосбаяр	Nogun ХХК, Гүйцэтгэх захирал	99004956	Nogun.est2010@gmail.com
11	Б.Баярням	УПТЭ Мон 8 төслийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэргэжилтэн	90565665	Bayarnyam@ndtc.mn
12	Т.Хүдэрчулуун	Эрдэнэт БОЭТ, Инженер техникийн тасгийн эрхлэгч	95929500	Hudre95@yahoo.com
13	Б.Энхсайхан	Амгалан амаржих газар, Инженер техникийн хэсгийн ахлагч	99005217	Saikhnaa_taga@yahoo.com
14	Б.Цэцэгсайхан	Цэргийн төв эмнэлэг, Инженер техникийн албаны дарга, ахмад	99052263	Tsetsegb2001@yahoo.com
15	Б.Зундуйдорж	ТТАХНЭ, Инженер техникийн албаны дарга	88053700	B.zundui1986@gmail.com
16	П.Намуунцэцэг	Монгол фарм ХХК, Инженер техникийн албаны дарга	99574440	Ts@mongolpharm.mn
17	Б.Баярсайхан	ГССҮТ, Инженер техникийн албаны ахлах инженер	99935196	Bayar0110@yahoo.com
18	Н.Амаржаргал	Өвөрхангайн эрүүл мэндийн газар, Мэргэлжилтэн	88322502	Amarjargal080801@gmail.com
19	Б.Чинзориг	Biomedical engineering ХХК, Гүйцэтгэх захирал	80088959	Admin@bme.mn
20	А.Жансерик	Баян-Өлгий аймаг, Инженер техникийн албаны дарга	990512709	Janka_mn@yahoo.com
21	Б.Сансартуяа	Мон анир ХХК, Программ хангамжийн тохируулгын инженер	88539332	sansartuya@monanir.mn

IV. Төгсөгчидтэй хийх уулзалт

№	Овог, нэр	Хэдэн оны төгсөгч	Албан тушаал	Утас	Мэйл хаяг
---	-----------	-------------------------	--------------	------	-----------

1	Б.Үржинбадам	2015	УБСонгдо эмнэлэг, Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер	88986644	urjee.univ@gmail.com
2	Г.Ган-Эрдэнэ	2015	БиосистемсХХК, Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер	99331092	ganaa1361@gmail.com
3	У.Батжаргал	2016	ХСҮТ, Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер	99183199	batjargalurnasan99@yahoo.com batjargalurnasan99@gmail.com
4	Х.Лхагва	2016	Этүгэн их сургууль, Сургалтын албаны мэргэжилтэн	99752922	lkhagva.h@etugen.edu.mn
5	О.Ганболд	2016	Сүвэн Уул ХХК, Инженер техникийн албаны ахлах инженер	88010871	ganbolganbold727@gmail.com
6	Б.Очиржанцан	2016	Гялс АУ-ны төв, ЭТТИ	99831744	ochirjantsan.b@gyals.mn
7	Ц.Хосбаяр	2017	СХДЭМТөв, Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер	88848388	tsogoohosoo@gmail.com
8	Д.Ганзориг	2017	УХТЭ-Цөмийн оношилгоо, эмчилгээний төв	99100299	Ganzorig.ndtc@gmail.com
9	Ж.Наранцэцэг	2017	Сетунари ХХК	89028920	Naraa.j111@gmail.com
10	Ө.Пүрэвбадмаа	2017	ХБХСЗХТ	98991001	jzhnitto@gmail.com
11	Ц.Энхболд	2018	Космос Тек Монгол ХХК	94980686	Enkhbold.ctm@outlook.com
12	Б.Күннур	2018	БӨАНЭ	95037070	b.kunnur55@gmail.com
13	П.Дуламсүрэн	2018	УНТЭ	88033307	dulamsurenpurew@gmail.com
14	Б.Баяндүүрэн	2018	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв	88680183	Baynaa6923@gmail.com
15	Э.Дашзэвэг	2019	СБЭМ	89740074	Zevegee0@gmail.com
16	З.Оюундалай	2019	Баянгол дүүргийн нэгдсэн эмнэлэг	94925054	oyundalaizandan@gmail.com
17	Н.Отгонсугар	2019	УНТЭ	99865390	Otgonsugar0523@gmail.com
18	Я.Энхболд	2019	АШУҮИС-н Монгол Японы	94340302	Enhboldenhee40@gmail.com

			ЭМНЭЛЭГ		
19	С.Дамбий	2020	Орхон БОЭТ	99364743	Dambii83@gmail.com
20	Г.Баярмаа	2020	Мэд буян ХХК	90111335	Bayarmaagankhuyag65@gmail.com
21	Б.Лена	2020	Мэд буян ХХК	89156335	bairjanlena@gmail.com

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал



ЭТҮГЭН ИХ СУРГУУЛЬ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Бээжингийн гудамж-29,
Утас: 31-91-50, Факс: 976-11-319150
www.etugen.edu.mn, info@etugen.mn

2021-12-07 № 192
танай _____ -ны № _____ -д

Г БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН Г ИТГЭМЖЛЭЛИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД

Тус сургуулийн Инженерчлэлийн тэнхимийн Үйлдвэрлэлийн автоматжуулалт (эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер) хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шинжээчдийн ирүүлсэн тайлан, сургалт судалгааны үйл ажиллагаанд хэрэгжүүлэх зөвлөмжтэй танилцлаа.

Зөвлөмжийг сургалтын хөтөлбөрийн үйл ажиллагаанд үе шаттайгаар тусган хэрэгжүүлэх болно.

РЕКТОР,
ДОК., ПРОФ.



Б.БАТСЭРЭЭДЭНЭ

СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Батлав: ЭИС-ийн ректор
 Баталгаажуулсан: ИЭЗМС-ийн захирал
 Хянасан: Тэнхимийн эрхлэгч

Б. Батсэрээдэнэ /док.проф/
 Л. Нямхүү /дэд. проф/
 Б.Оргилмаа /Ахлах багш, магистр/

2020-2021 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Мэргэжил: Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер
 Боловсролын зэрэг: Бакалавр
 Суралцах хэлбэр: Өдөр

Мэргэжлийн индекс: 071402
 Элсэгчдийн боловсролын : Бүрэн дунд
 Суралцах хугацаа : 4 жил

I дамжаа		II дамжаа	
1-р улирал	кредит	3-р улирал	кредит
Монголын түүх, соёл ёс заншил	3	Цахилгаан техникийн онол- II	3
Монгол хэл бичиг, найруулга зүй	3	Анагаахын физик	2
Хүний хөгжил, харилцааны ёс зүй, эрх зүй	3	Биохими	2
Математик-I	3	Мэргэжлийн удиртгал	2
Физик -I	3	Физиологи	3
Мэдээллийн технологи, мэдээллийн систем	2	Хөдөлмөр хамгаалал	2
Англи хэл	3	Биоматериал судлал	2
Биеийн тамир	1	Харилцааны ур чадвар	1
Нийт кредит	21	Нийт кредит	16
III дамжаа		IV дамжаа	
5-р улирал	кредит	7-р улирал	кредит
Лаборатори шинжилгээний үндэс ба төхөөрөмж	3	Дүрслэл оношилгооны тоног төхөөрөмж	3
Биоэлектроник ба хэмжлэгийн техник	3	Эмнэлгийн тоног төхөөрөмж багаж хэрэгсэл- I	3
Микро электроник	3	Рентген төхөөрөмж	3
Инженерийн зураг зүйн автоматжуулалт	2	Мэдээлэл дамжуулалт ба интерфейс	2
Цахилгаан төхөөрөмж	3	Анагаахын дүрс боловсруулалт	2
Программчлалын үндэс	3	Эмнэлгийн ёс зүй	1
Мэргэжлийн ёс зүй	1	Мэргэшүүлэх хичээлийн курсийн ажил	1
Нийт кредит	18	Нийт кредит	15
VI дамжаа		VII дамжаа	
6-р улирал	кредит	8-р улирал	кредит
Функциональ оношилгооны тоног төхөөрөмж	3	Үйлдвэрийн даллага II	3
Эмнэлэг биологийн электроник	3	Эмнэлгийн тоног төхөөрөмж багаж хэрэгсэл II	3
Программ шаралт	2	Төгсөлтийн шалгалт/ Онол ур чадварын нэгдсэн шалгалт	3
Зохион бүтээх ажил	2		
Мэргэжлийн англи хэл	3		
Мэргэжлийн эмнэлгийн ёс зүй	1		
Бизнес төсөл	1		
Үйлдвэрийн даллага I	2		
Нийт кредит	17	Нийт кредит	9
Нийт 133 кр			